


МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

<p>2</p>  <p>БҮХ НИЙТЭЭР АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ</p>	<p>1</p>  <p>ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БУУРУУЛАХ</p>	<p>3</p>  <p>ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ</p>	<p>4</p>  <p>ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ</p>
<p>5</p>  <p>ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ</p>	<p>6</p>  <p>БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ХДХВ, ДОХ, СУРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, БУСАД ӨВЧНИЙГ БУУРУУЛАХ</p>	<p>7</p>  <p>БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ</p>	<p>8</p>  <p>ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ</p>





МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО

**МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН
ЗАРИМ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Улаанбаатар хот
2011 он

АГУУЛГА

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	iv
ТОВЧИЛСОН ҮГСНИЙН ЖАГСААЛТ	vi
ӨМНӨХ ҮГ	1
НИЙТЛЭГ ЗҮЙЛ	2
БҮЛЭГ I. ТАНИЛЦУУЛГА	5
ЗОРИЛГО НЭГ: ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БУУРУУЛАХ	5
Зорилт 3: Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлж, хөдөлмөрийн зах зээлд шилжиж буй залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах	5
1.8 Ажиллах хүчний оролцооны түвшин	6
ЗОРИЛГО ХОЁР: БҮХ НИЙТЭЭР АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ	13
Зорилт 5: 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох	13
2.1 Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин	14
2.3 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь	18
ЗОРИЛГО ГУРАВ: ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ	23
Зорилт 6: 2009 он гэхэд бага болон бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдын хүйсийн зохистой байдлыг хангах	23
3.1 Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	24
3.2 Дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	27
Зорилт 7: Цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын жендерийн тэгш байдлыг хангах	31
3.4 ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	32
ЗОРИЛГО ДОЛОО: БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ	37
Зорилт 16: 2015 он гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах	37

7.8 Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь	38
Зорилт 17: 2015 он гэхэд хүн амын орон сууцны нөхцлийг сайжруулах	43
7.10 Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь	44
ЗОРИЛГО НАЙМ: ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ	49
Зорилт 21: Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, “Мэдээлэлжсэн нийгэм байгуулах”	49
8.13 Интернет байнгын хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд)	50
8.14 Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд)	53
БҮЛЭГ II. ДҮГНЭЛТ, ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ	57
АШИГЛАСАН НОМ, ТОВХИМОЛ	62
ХАВСРАЛТ	63

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хөдөлмөрийн насны хүн амын тоо, бүс нутгаар, 2000, 2010 он	7
Хүснэгт 2. Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2000, 2010 он	8
Хүснэгт 3. Ажиллах хүчний оролцооны түвшин, бүс нутаг, хувиар	9
Хүснэгт 4. Ажиллах хүчний оролцооны түвшин, бүс нутаг, аймаг, нийслэл, хүйс, хувиар, 2000, 2010 он	10
Хүснэгт 5. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он	11
Хүснэгт 6. Ажиллах хүчний оролцооны түвшин, хот, хөдөө, хүйсээр, 2000, 2010 он	12
Хүснэгт 7. Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин, хувиар	15
Хүснэгт 8. Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин, бүс нутаг, аймаг, нийслэл, хүйс, хувиар, 2010 он	15
Хүснэгт 9. Бага боловсролын хамран сургалтын үзүүлэлтүүд, бүс нутаг, хүйс, хувиар, 2010 он	16
Хүснэгт 10. Бичиг үсэг тайлагдалтын түвшин, хувиар	18
Хүснэгт 11. Бичиг үсэг тайлагдалтын түвшин, бүс нутаг, аймаг, нийслэл, хувиар, 2000, 2010 он	19
Хүснэгт 12. Бичиг үсэг тайлагдалтын түвшин, бүс нутаг, хот, хөдөө, хүйс, хувиар, 2010 он	20
Хүснэгт 13. Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	24
Хүснэгт 14. Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тоо, харьцаа, бүс нутаг, аймаг, нийслэлээр, 2000, 2010 он	25
Хүснэгт 15. Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа, бүс нутаг, хот, хөдөөгөөр, 2010 он	26
Хүснэгт 16. Дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	27
Хүснэгт 17. Дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тоо, тэдний харьцаа, бүс нутаг, аймаг, нийслэлээр, 2000, 2010 он	28
Хүснэгт 18. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	32
Хүснэгт 19. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, бүс нутаг, аймаг, нийслэлээр, 2000, 2010 он	33
Хүснэгт 20. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2000, 2010 он	35
Хүснэгт 21. Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь	38
Хүснэгт 22. Хүн амын ундны усны эх үүсвэр, бүс нутгаар, 2010 он	39
Хүснэгт 23. Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь, бүс нутаг, аймаг, нийслэлээр, 2000, 2010 он	40
Хүснэгт 24. Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь	44
Хүснэгт 25. Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь, бүс нутаг, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он	45
Хүснэгт 26. Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн ам, сууцны төрлөөр, бүс нутаг, аймаг, нийслэлээр, 2010 он	46

Хүснэгт 27. Интернет байнгын хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд)	51
Хүснэгт 28. Интернет байнгын хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд), бүс нутаг, аймаг, нийслэл, хүйсээр, 2010 он	51
Хүснэгт 29. Интернет байнгын хэрэглэгчдийн тоо, мян.хүн, бүс нутаг, хот, хөдөө, хүйсээр, 2010 он	52
Хүснэгт 30. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (6, түүнээс дээш насны хүн ам), бүс нутаг, аймаг, нийслэл, хүйсээр, 2010 он	54
Хүснэгт 31. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд)	55
Хүснэгт 32. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд), бүс нутаг, хот, хөдөө, хүйсээр, 2010 он	55
Зураг 1. Эдийн засгийн идэвхтэй хүн амын зарим үзүүлэлт, бүс нутаг, хувиар, 2010 он	8
Зураг 2. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин, бүс нутаг, хувиар, 2010 он	11
Зураг 3. 6-11 насны нийт болон сургуульд суралцаж байгаа эрэгтэй, эмэгтэй хүүхдийн хүйсийн харьцаа, бүс нутаг, хувиар, 2010 он	17
Зураг 4. Бичиг үсэг тайлагдалтын түвшин, бүс нутаг, хүйс, хувиар, 2010 он	21
Зураг 5. Дунд шатны боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа, бүс нутаг, хот, хөдөөгөөр, 2010 он	29
Зураг 6. ХАА-н бус салбарт цалинтай ажил эрхэлж байгаа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн харьцаа, бүс нутаг, хувиар, 2010 он	35
Зураг 7. Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь, бүс нутаг, хот, хөдөөгөөр, 2010 он	39
Зураг 8. Интернет байнгын хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд), бүс нутаг, хот, хөдөө, хувиар, 2010 он	52

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХАОСТ	Хүн ам, орон сууны тооллого
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ШСГ	Шинжилгээ судалгааны газар
МШХХТГ	Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
СЯ	Сангийн яам
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ХАА	Хөдөө аж ахуй
АХОТ	Ажиллах хүчний оролцооны түвшин
ӨОЗС	Өрхийн орлого, зарлагын судалгаа
АТТС	Амьжиргааны түвшний түүвэр судалгаа

ӨМНӨХ ҮГ



Шинэ мянганы шинэ зууны босгон дээр дэлхийн улс орнуудын төр, засгийн тэргүүн нар чуулж, “Мянганы тунхаглал” хэмээх түүхэн баримт бичгийг батласан билээ. Энэхүү тунхаглалын дагуу хөгжлийн бүхий л талыг хамарсан МХЗ-уудыг тодорхойлж, тэдгээрийг 2015 он гэхэд хангах үүргийг улс орон бүр хүлээж, товлосон хугацаа болоход 5 жил хүрэхгүй хугацаа үлдэж байна.

Монгол Улс нь МХЗ-уудын хэрэгжилтийг хангахад тэргүүлэх ач холбогдол өгч, үндэсний зорилтуудаа батлан, 2015 он гэхэд хүрэх түвшингээ тодорхойлон хэрэгжүүлж байна. Монгол Улсын МХЗ-ууд нь 9 зорилго, 24 зорилт, 67 шалгуур үзүүлэлтээс бүрдэж байна. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг ҮСХ-ноос эрхлэн гаргаж буй албан ёсны статистикийн мэдээ, тооллого, судалгааны дүн болон Засгийн

газар, Яамд, төрийн бусад байгууллагуудын захиргааны статистикийн мэдээлэлд үндэслэн тооцон гаргаж байна.

Улс орнууд хүн амаа 10 жил тутам тоолж байх НҮБ-ын зөвлөмжийн дагуу Монгол улс хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг “Хүмүүнд төр эрхэм, төрд хүмүүн эрдэнэ” уриан дор 2010 оны 11 сарын 11-нээс 17-ны хооронд амжилттай зохион байгуулсан. Энэхүү тооллогын үр дүнд үндэслэн Монгол улсын МХЗ-ын зарим шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийн явцыг 2010 оны байдлаар улс, аймаг, нийслэл, бүс нутгаар тодорхойлох, цаашдын зорилго, зорилтыг төлөвлөх боломж бүрдлээ.

Тооллогын үр дүнгээр Монгол улсын МХЗ-ын зарим үзүүлэлтүүдийн хэрэгжилтэд ахиц, дэвшил гарсныг тэмдэглэх нь зүйтэй. Мэдээлэл, харилцаа холбооны технологи өндөр хөгжсөн өнөө үед Монголчуудын интернет болон үүрэн телефоны байнгын хэрэглээнд ихээхэн дэвшил гарсан байна. Эдгээр үзүүлэлт нь 2015 оны зорилтоо хангажээ. Түүнчлэн Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй боловсролын салбарын бодлогын үр дүнд бага боловсролын хамран сургалтын жин, 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь, бага болон дунд боловсрол эзэмшигч охид, хөвгүүдийн харьцаа зэрэг үзүүлэлт нь 2015 онд тавьсан зорилтод хүрэхэд ойрхон байна.

Гэвч ахиц, ололтын зэрэгцээ зарим нэгэн үзүүлэлтийн хэрэгжилт ихээхэн удаашралтай, хангалтгүй байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 2010 онд улсын дунджаар 56.4 хувь байгаа нь 2000 оныхоос 5.5 пунктээр, 2005 оныхоос 7.1 пунктээр буурсан байна. Монгол улсын хот, хөдөөгийн хөгжлийн түвшин хоорондоо ялгаатай учир МХЗ-уудын хэрэгжилт орон нутагт харилцан адилгүй байна.

Хүн ам, орон сууцны тооллогын үр дүнд үндэслэн МХЗ-ын зарим шалгуур үзүүлэлтүүдийн өнөөгийн байдлыг тодорхойлсон энэхүү сэдэвчилсэн судалгаа нь тооллогын үр дүнгийн талаар хэрэглэгчдэд үнэтэй мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

ҮСХ-НЫ ДАРГА



С.МЭНДСАЙХАН

МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ЗАРИМ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ ТООЛЛОГЫН ДҮНД ҮНДЭСЛЭН ХИЙСЭН СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА

НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Хүн төрөлхтний өмнө тулгамдсан асуудлаар дэлхий нийтийн анхаарлыг төвлөрүүлж, зөвшилцөлд хүрч, шийдвэрлэсэн чухал асуудал бол Мянганы Хөгжлийн Зорилтуудыг хэрэгжүүлэхээр тохиролцсон явдал юм. 2000 оны 9 дүгээр сард Нью-Йорк хотноо болсон дэлхийн 189 орны төр, засгийн тэргүүн оролцсон НҮБ-ын Мянганы Чуулганд манай Ерөнхийлөгч асан Н.Багабанди Мянганы Тунхаглалыг дэмжин гарын үсэг зурснаар Монгол Улс энэхүү зорилтуудыг 2015 оныг хүртэл хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн билээ. Дэлхий нийтээрээ хөгжиж байгаа орнуудын хөгжлийн тулгамдсан асуудлыг Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилттэй шууд холбон авч үздэг болсон.

УИХ-аас 2005 оны 4 дүгээр сард 25 дугаар тогтоол гарч, НҮБ-аас зөвлөмж болгосон Мянганы хөгжлийн зорилтуудад хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх зорилтыг шинээр нэмж тусган, 2015 он хүртэл хэрэгжүүлэх Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудыг тодорхойлсон билээ. НҮБ-аас 2003 оны 9 сард анх батлан гаргасан Мянганы Хөгжлийн Зорилтууд нь 8 зорилго, 18 зорилт, тэдгээрийг дүгнэх 48 үзүүлэлттэй байсан. Харин НҮБ-аас 2008 оны 1-р сараас эхлэн мөрдүүлэхээр зөвлөмж болгосноор Мянганы Хөгжлийн Зорилтууд нь 8 зорилго, 21 зорилт, тэдгээрийг дүгнэх 60 үзүүлэлттэй болж өөрчлөгдсөн.

УИХ-аас 2008 оны 1-р сард 13 дугаар тогтоол гарч, 2005 оны 25-р тогтоолд өөрчлөлт оруулж шинэчилсэн бөгөөд Мянганы Хөгжлийн Зорилтууд нь 9 зорилго, 24 зорилт, тэдгээрийг 67 үзүүлэлтээр дүгнэхээр болсон юм. Өнөөгийн байдлаар нийт 67 үзүүлэлтээс 65 үзүүлэлтийг бүрэн тооцож, харин 2 үзүүлэлт тооцогдохгүй байна.

Эдгээр 65 үзүүлэлтийн 21 үзүүлэлтийг ҮСХ-ны албан ёсны статистикийн мэдээлэл, тооллого, судалгаанаас, 12 үзүүлэлтийг ЭМЯ, 5 үзүүлэлтийг БСШУЯ, 7 үзүүлэлтийг БОАЖЯ, 3 үзүүлэлтийг ХЗДХЯ, 10 үзүүлэлтийг СЯ, 4 үзүүлэлтийг бусад байгууллагын захиргааны статистикийн мэдээллээс тооцон гаргаж байна.

Статистик мэдээллийн бодит байдлыг хангах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн өсөн нэмэгдэж байгаа олон талт хэрэгцээг хангах зорилгоор 2010 оны 11 сарын 11-17-ны хооронд явагдсан Монгол улсын Хүн ам, орон сууцны ээлжит тооллогын үр дүнд үндэслэн МХЗ-ын хэрэгжилтийг хянах зарим шалгуур үзүүлэлтүүдийг тооцон, хэрэгжилтийн явцыг харуулж, санал, дүгнэлт өгснийг энэхүү тусгайлсан судалгаагаар танилцуулж байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын үр дүнд үндэслэн тооцсон МХЗ-ын зарим үзүүлэлтүүдийг Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнтэй зэрэгцүүлж, харин энэ удаагийн тооллогоор анх удаа тооцсон зарим үзүүлэлтүүдийг өмнөх тооллогынхтой зэрэгцүүлэх боломжгүй учир бусад эх үүсвэртэй нь харьцуулсан болно.

МХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолтыг ҮСХ-ны даргын 2008 оны 12 сарын 31-ний өдрийн 182 тоот тушаалаар батлагдсан “Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал”-ын дагуу авсан болно.

Энэхүү “МХЗ-ын зарим шалгуур үзүүлэлтүүд” сэдэвчилсэн судалгаа нь 2 бүлгээс бүрдэж байна. Эхний бүлэгт 2010 оны Монгол улсын Хүн ам, орон сууцны тооллогын үр дүнд үндэслэн тооцсон МХЗ-ын Зорилго 1-ийн Зорилт 3-ын 1.8-р үзүүлэлт; Зорилго 2-ын Зорилт 5-ын 2.1 болон 2.3-р үзүүлэлтүүд; Зорилго 3-ын Зорилт 6-ын 3.1 болон 3.2-р үзүүлэлтүүд болон Зорилт 7-ын 3.4-р үзүүлэлт; Зорилго 7-гийн Зорилт 16-ын 7.8 болон Зорилт 17-ын 7.10-р үзүүлэлт; Зорилго 8-ын Зорилт 21-ийн 8.13 болон 8.14-р үзүүлэлтүүд болох нийт 10 шалгуур үзүүлэлтийн өнөөгийн байдлын талаар танилцуулна. Хоёрдугаар бүлэгт Дүгнэлт, цаашид анхаарах асуудал багтаж байна.



Хрмррд твр зрхэм. Тлрд хрмррн эрдэнэ

БҮЛЭГ I. ТАНИЛЦУУЛГА



1

ЯДУУРАЛ,
ӨЛСГӨЛӨНГ
БУУРУУЛАХ

ЗОРИЛГО НЭГ: ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БУУРУУЛАХ

ЗОРИЛТ 3: ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИНГ ДЭЭШЛҮҮЛЖ, ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛД ШИЛЖИЖ БУЙ ЗАЛУУЧУУДЫН АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИНГ БУУРУУЛАХ

ҮЗҮҮЛЭЛТ:

1.8 *Ажиллах хүчний оролцооны түвшин*

1.8 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ТООЦОХ АРГА ЗҮЙ

Ажиллах хүчний оролцооны түвшин нь хөдөлмөрийн насны хүн амын дунд ажиллах хүч буюу ажил эрхэлж байгаа болон ажил идэвхтэй эрж, хайж байгаа, ажиллахад бэлэн ажилгүй хүн амын эзлэх хувь болно. Энэхүү үзүүлэлт нь хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийн байдал, эдийн засагт хөдөлмөрийн насны хүн амыг ажлын байраар хангах зорилтын хэрэгжилтийг хянах хэмжүүр юм.

Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын аргачлалын дагуу ажиллагчид болон хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийг хамруулна. Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй хүн амыг “байнгын идэвх” гэсэн ойлголтод тулгуурлаж тодорхойлдог. Хөдөлмөрийн насны ажил эрхэлдэггүй, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлгүй хүмүүс, хөдөлмөрийн насны суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол хүмүүсийг ажиллах хүчинд хамааруулахгүй.

Ажиллах хүчний оролцооны түвшинг эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын суурин хүн амын тоо 2010 оны 11 сарын 11-ний байдлаар 2754.7 мянга, хөдөлмөрийн насны (15, түүнээс дээш насны) хүн амын тоо 1906.0 мянга, эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 1075.8 мянга болжээ.

Хөдөлмөрийн насны нийт хүн ам

Тооллогын үед хөдөлмөрийн насны нийт эрэгтэйчүүдийн тоо 937.3 мянга, эмэгтэйчүүдийн тоо 968.7 мянгад хүрсэн байна. Хөдөлмөрийн насны нийт хүн амын тоо 2010 онд 2000 оныхоос даруй 25 хувиар өсчээ. Улаанбаатар хотод хөдөлмөрийн насны нийт хүн амын дийлэнх буюу 45.7 хувь нь амьдарч байгаа бол Зүүн бүсэд хамгийн бага буюу 6.8 хувь нь амьдарч байна.

Улаанбаатараас бусад бүх бүсийн хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн насны нийт хүн амд эзлэх хувь 2010 онд 2000 оныхоос 1.5-4.3 пунктээр буурсан байна. Харин Улаанбаатар хотын хөдөлмөрийн насны хүн амын тоо 64.1 хувиар, хөдөлмөрийн насны нийт хүн амд эзлэх хувь 10.9 пунктээр нэмэгдсэн байна. Үүнийг сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйд тохиолдсон байгалийн гамшигт үзэгдлээс шалтгаалан хөдөөгийн олон тооны өрхүүд малгүй болж, хот суурин газарт амьдралын илүү боломжийг хайн шилжин ирж байгаатай холбон тайлбарлаж болно.

Хүснэгт 1. Хөдөлмөрийн насны хүн амын тоо, бүс нутгаар, 2000, 2010 он

Бүс	2000		2010	
	15, түүнээс дээш хөдөлмөрийн насны хүн амын тоо	Бүсүүдийн эзлэх хувь	15, түүнээс дээш хөдөлмөрийн насны хүн амын тоо	Бүсүүдийн эзлэх хувь
Улсын дундаж	1 524 372	100.0	1 905 969	100.0
Баруун бүс	250 700	16.4	231 103	12.1
Хангайн бүс	335 573	22.0	357 340	18.7
Төвийн бүс	280 724	18.4	315 649	16.6
Зүүн бүс	126 130	8.3	130 017	6.8
Улаанбаатар	531 245	34.9	871 860	45.8

Хөдөлмөрийн насны нийт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хөдөлмөрийн насны нийт хүн амд эзлэх хувийн жин улсын түвшинд 50.8 болон 49.2 хувьтай байгаа нь Монгол улсын хөдөлмөрийн насны хүн ам дахь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн оролцоо бараг тэнцүү байгааг харуулж байна.

Хөдөлмөрийн насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн харьцаа улсын түвшинд дунджаар 103.4 хувьтай байна.

Харин Улаанбаатар хотын хөдөлмөрийн насны эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн насны нийт хүн амд эзлэх хувийн жин нь 52.4 болон 47.6 хувь, Төвийн бүсийнх 48.1 болон 51.9 хувьтай байгаа нь бусад бүсүүдтэй харьцуулахад нэлээд их зөрүүтэй байна.

Улаанбаатар хотод хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийн тооноос 10.1 хувиар дээгүүр байгаа бол Төвийн бүсэд хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн тоо нь эрэгтэйчүүдийнхээс 7.4 хувиар доогуур байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн ам

Тооллогоор тооллогын өмнөх 7 хоногт бараа, үйлчилгээг бий болгоход оролцсон буюу ажил эрхэлсэн эсвэл ажил хайж байсан гэж 1075.8 мян.хүн хариулсан нь Монгол улсын нийт ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог илэрхийлж байна. Үүнээс эдийн засгийн идэвхтэй эрэгтэй хүн амын тоо 590.1 мянга, эмэгтэй хүн амын тоо 485.6 мянга болж байна.

Эдийн засгийн идэвхтэй эрэгтэйчүүдийн тоо нь эмэгтэйчүүдийнхээс 21.5 хувиар өндөр буюу 104.5 мянган хүнээр илүү байгаа нь Монгол улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа болон ажил хөдөлмөр идэвхтэй эрж хайж, бүртгүүлсэн хүмүүсийн дийлэнх нь эрэгтэйчүүд байгааг илтгэж байна.

Аль ч насны бүлэгт эдийн засгийн идэвхтэй эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдийнхээс өндөр байна.


Хүснэгт 2. Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2000, 2010 он

Насны бүлэг	2000			2010		
	БҮГД	Эрэгтэй	Эмэгтэй	БҮГД	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	944.1	514.2	429.9	1075.8	590.1	485.6
15-19	108.6	63.9	44.7	37.1	25.9	11.2
20-24	159.6	88.0	71.6	161.3	94.4	66.9
25-34	309.3	162.4	146.8	357.3	195.6	161.6
35-44	236.7	120.5	116.2	295.2	151.7	143.4
45-54	91.3	52.7	38.6	186.2	96.1	90.1
55-59	23.3	17.0	6.4	26.1	17.9	8.2
60+	15.3	9.7	5.6	12.6	8.5	4.1

Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 2010 онд 2000 оныхоос 131.7 мянган хүнээр буюу 14 хувиар өссөн байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 48.2 хувь нь 20-34 насны залуучууд байна.

Эдийн засгийн идэвхтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эдийн засгийн идэвхтэй нийт хүн амд эзлэх хувийн зөрүү нь улсын түвшинд 9.7 пункт байна. Энэ зөрүү Төвийн бүсэд хамгийн өндөр буюу 15.0 пункт байхад Улаанбаатар хотод хамгийн бага буюу 7.6 пункт байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амын дийлэнх буюу 42.0 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна.

Зураг 1. Эдийн засгийн идэвхтэй хүн амын зарим үзүүлэлт, бүс нутаг, хувиар, 2010 он



Ажиллах хүчний оролцооны түвшин

Монгол улс ажиллах хүчний оролцооны түвшинг 2015 он гэхэд 70.0 хувьд хүргэх зорилт тавьсан. Тооллогын дүнгээс тооцсон ажиллах хүчний оролцооны түвшин 2010 онд улсын дунджаар 56.4 хувь, үүнээс эмэгтэйчүүдийнх 50.1 хувь, эрэгтэйчүүдийнх 63.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Ажиллах хүчний оролцооны түвшин, бүс нутаг, хувиар

Бүс	Явц		Зорилт	
	2000	2005*	2010	2015
Улсын дундаж	61.9	63.5	56.4	70.0
Баруун бүс	68.3	72.9	58.0	
Хангайн бүс	70.1	73.0	61.7	
Төвийн бүс	64.9	65.6	61.2	
Зүүн бүс	63.6	61.3	58.4	
Улаанбаатар	51.8	54.4	51.9	

Мэдээллийн эх үүсвэр: * ҮСХ. Хүн амын ажил эрхлэлтийн жилийн тайлан

Улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин нэмэгдэхгүй, харин ч 2000 оныхоос 5.5 пунктээр, 2005 оныхоос 7.1 пунктээр буурсан байна. Хөдөлмөрийн насны хүн амын өсөлт өндөр байгаа хэдий ч Монгол улсын эдийн засаг дахь хөдөлмөрийн зах зээлийн багтаамж бага байгаа нь ажиллах хүчний оролцооны түвшин буурахад нөлөөлж байна.

Хүснэгт 4. Ажиллах хүчний оролцооны түвшин, бүс нутаг, аймаг, нийслэл, хүйс, хувиар, 2000, 2010 он

	2000			2010		
	БҮГД	Эрэгтэй	Эмэгтэй	БҮГД	Эрэгтэй	Эмэгтэй
Улсын дундаж	61.9	68.6	55.5	56.4	63.0	50.1
Баруун бүс	68.3	76.0	60.7	58.0	64.6	51.4
Баян-Өлгий	63.8	72.5	55.0	54.2	62.5	46.0
Говь-Алтай	76.1	82.2	70.2	62.4	68.7	56.1
Завхан	69.9	77.0	63.0	58.8	64.3	53.4
Увс	67.8	75.3	60.3	60.4	66.1	54.7
Ховд	65.5	74.6	56.6	55.9	62.8	49.1
Хангайн бүс	70.1	76.2	64.1	61.7	67.2	56.3
Архангай	69.1	75.3	62.8	63.9	69.5	58.4
Баянхонгор	74.8	80.6	69.2	65.2	69.5	60.8
Булган	67.4	73.8	60.8	65.3	69.7	60.7
Орхон	62.4	68.8	56.1	56.5	62.8	50.6
Өвөрхангай	75.1	80.5	69.8	62.1	67.9	56.3
Хөвсгөл	69.4	76.0	63.1	60.1	65.8	54.6
Төвийн бүс	64.9	71.6	58.2	61.2	67.7	54.1
Говьсүмбэр	59.8	64.7	54.7	62.7	67.3	57.8
Дархан-Уул	54.6	61.2	48.4	52.5	59.0	46.4
Дорноговь	71.4	79.0	63.5	63.9	71.3	56.4
Дундговь	76.4	81.5	71.3	65.8	69.8	61.7
Өмнөговь	77.6	83.2	72.0	74.7	81.9	64.1
Сэлэнгэ	57.4	64.5	49.8	57.7	63.5	51.6
Төв	67.2	74.0	59.8	60.3	66.0	54.0
Зүүн бүс	63.6	70.7	56.6	58.4	64.2	52.4
Дорнод	56.3	63.4	49.3	53.3	59.5	47.0
Сүхбаатар	70.5	77.7	63.0	63.6	69.6	57.4
Хэнтий	66.1	72.7	59.4	59.6	64.8	54.3
Улаанбаатар	51.8	57.7	46.3	51.9	58.6	45.8

Ажиллах хүчний оролцооны түвшин 2000 онд Хангайн бүсэд хамгийн өндөр 70.1 хувь байсан бол Улаанбаатар хотод хамгийн бага 51.8 хувь байв. Энэ түвшин 2010 онд хэвээр хадгалагдаж, Хангайн бүсэд ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн өндөр буюу 61.7 хувь, Улаанбаатар хотод хамгийн бага буюу 51.9 хувь байна.

Эндээс хотын хүн амын тоо болон ажиллах хүчний оролцооны түвшний хооронд хамаарал байгааг харж болно. Өөрөөр хэлбэл хотын хүн амын тоо өндөр байхад ажиллах хүчний оролцооны түвшин нь доогуур байна. Хотжилт өндөртэй Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Дорнод аймгуудад ажиллах

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО: МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ЗАРИМ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

хүчний оролцоо бусад аймагтай харьцуулахад нэлээд доогуур байна.


Ажиллах хүчний оролцооны түвшин 2010 онд Өмнөговь аймагт хамгийн өндөр 74.7 хувьтай байгаа нь тус аймагт хөдөлмөр эрхлэлтийн түвшин өндөр байгааг илтгэж байна. Үүнийг тус аймагт хэрэгжиж байгаа дэлхийд нөөцөөрөө тэргүүлж буй алт, зэсийн Оюу толгой төслийн үйл ажиллагаатай буюу энэ төсөлд хамгийн түрүүнд Өмнөговь аймгийн иргэд ажлын байраар хангагдаж байгаатай холбон тайлбарлаж болох юм.

Хүснэгт 5. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйс, хувиар, 2000, 2010 он

Насны бүлэг	2000			2010		
	БҮГД	Эрэгтэй	Эмэгтэй	БҮГД	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	61.9	68.6	55.5	56.4	63.0	50.1
15-19	41.2	48.0	34.4	14.4	19.8	8.8
20-24	67.7	74.5	60.8	55.2	64.0	46.2
25-34	76.5	81.0	72.0	75.9	82.8	69.1
35-44	78.9	81.7	76.3	77.3	80.2	74.5
45-54	64.9	77.1	53.3	66.3	70.9	62.0
55-59	41.8	62.0	22.3	36.3	53.7	21.3
60+	12.3	17.7	8.0	8.4	13.1	4.8

Ажиллах хүчний оролцооны түвшин 2010 онд 2000 оныхоос 45-54 насны бүлгээс бусад бүх насны бүлэгт буурсан байна. Үүний дотор 15-19 болон 20-24 насны залуучуудын ажиллах хүчний оролцооны түвшин 26.8 болон 12.5 пунктээр буурсан нь энэ насны залуучуудын сургуульд хамрагдалт нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж болох юм. Харин 45-54 насны эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 8.7 пунктээр нэмэгдсэн нь эмэгтэйчүүдийн 10 жилийн өмнөх эдийн засгийн идэвх хадгалагдаж байна гэж үзэж болохоор байна.

Зураг 2. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин, бүс нутаг, хувиар, 2010 он



Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 2010 онд Улаанбаатар хотод хамгийн бага 58.6 болон 45.8 хувьтай байхад эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин Төвийн бүсэд хамгийн өндөр 67.7 хувьтай, харин эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин Хангайн бүсэд хамгийн өндөр 56.3 хувьтай байна.

Хүснэгт 6. Ажиллах хүчний оролцооны түвшин, хот, хөдөө, хүйсээр, 2000, 2010 он

	БҮГД	Хот		БҮГД	Хөдөө	
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
АХОТ, 2000 он	53.8	60.2	47.9	73.6	80.1	66.9
АХОТ, 2010 он	52.3	58.5	46.5	66.1	72.4	59.3

Ажиллах хүчний оролцооны түвшин хөдөөд хотоос 13.8 пунктээр илүү байгаа нь манай улсын онцлог гэж хэлж болно. Тооллогоор хөдөөгийн малчин өрхийн 15, түүнээс дээш настай хүн амыг үндсэнд нь ажил эрхэлдэг гэж үздэгээс шалтгаалан хөдөөгийн ажиллах хүчний оролцооны түвшин өндөр гарсан байна. Хөдөөгийн хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин 2010 онд 2000 оны тооллогын үеийнхээс 7.5 пунктээр буурчээ.

Хүйсээр авч үзэхэд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь ажиллах хүчний оролцоо хөдөөд хотынхоос өндөр байна. Хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 2000 болон 2010 онд 80.1 болон 72.4 хувь байгаа нь хотын эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшнээс 19.9 болон 13.9 пунктээр илүү байна.

Хөдөлмөрийн насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хүйсийн харьцаа 2010 онд улсын хэмжээнд 1.03 байхад харин эдийн засгийн идэвхтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн харьцаа 0.82 байна. Түүнчлэн эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэйчүүдийнхээс 12.9 пунктээр доогуур байна. Энэ нь эмэгтэйчүүд хүүхэд асрах, гэрийн ажил хийх, эрэгтэйчүүдээс эрт тэтгэвэрт гарах зэрэг хүчин зүйлсийн нөлөөллөөр эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвх нь эрэгтэйчүүдийнхээс доогуур байгааг илтгэж байна.

2015 он хүртэл үлдсэн 5 жилийн хугацаанд ажиллах хүчний оролцооны түвшний тавьсан зорилтод хүрэхэд даруй 13.6 пункт дутуу байна. Энэ нь 2015 онд уг үзүүлэлтийг 70 хувьд хүргэх зорилтыг хангахад онцгой анхаарах шаардлагатайг харуулж байна.

Тиймээс Монгол Улсын Засгийн газраас ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, ялангуяа хангалттай цалинтай ажлын байрыг бий болгох талаар хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгаж хэрэгжүүлэх явдлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.



2

БҮХ НИЙТЭЭР
АНХАН ШАТНЫ
БОЛОВСРОЛ
ЭЗЭМШИХ

ЗОРИЛГО ХОЁР. БҮХ НИЙТЭЭР АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ

ЗОРИЛТ 5: 2015 ОН ГЭХЭД БҮХ ХҮҮХДЭД БАГА
БОЛОВСРОЛ ОЛГОХ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

- 2.1 Бага боловсролын хамран сургалт
- 2.3 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшин

2.1 БАГА БОЛОВСРОЛЫН ХАМРАН СУРГАЛТ

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ТООЦОХ АРГА ЗҮЙ

Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин нь бага боловсролд хамрагдвал зохих насны нийт хүүхдүүдээс бага боловсролд хамрагдаж буй хүүхдийн тоог хувиар илэрхийлсэн үзүүлэлт юм. Бага боловсролд хамрагдвал зохих насны хүн амд 6-11 насны нийт хүүхдүүдийг хамруулна.

Уг үзүүлэлтээр бага боловсролд хамрагдвал зохих насны хүүхдүүдийн сургуульд бүрэн хамрагдаж байгаа эсэхийг өөрөөр хэлбэл, бага боловсролын үйлчилгээний хүртээмжийг хянана. Энэ шалгуур үзүүлэлтийн утга нь 100-д ойрхон байх тусам хамран сургалт өндөр байгааг илэрхийлнэ.

Бага боловсролын хамран сургалтыг бага боловсролд хамрагдвал зохих буюу 6-11 насандаа хамрагдсан хүүхдийн тоог 6-11 насны нийт хүн амын тоонд харьцуулж тооцно.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улс сургуулийн насны хүүхдийг сургуульд бүрэн хамруулах, улмаар сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийг сургуулиас завсардуулахгүйгээр зохих түвшний боловсрол эзэмшүүлэх талаар ихээхэн анхаарч ирсэн. Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжил болоод олон улсын боловсролын тогтолцоотой уялдуулан 2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөрийн дагуу 6 настай хүүхдийг 1 дүгээр ангид элсүүлэх болсон билээ.

Монгол улс 2015 он гэхэд бага боловсролын хамран сургалтын цэвэр жинг 100 хувьд хүргэх зорилт тавьсан. Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 1995 онд 97.5 хувьтай байсан бол 2000 онд 95.0 хувь, 2005 онд 93.3 хувь болж буурах хандлагатай байснаа 2010 оны тооллогын дүнгээр 97.4 хувь болж өсчээ. Энд 2008-2009 оноос өмнөх онуудын бага боловсролын хамран сургалтын цэвэр жинг тухайн үеийн “Бага, дунд боловсролын тухай” хуульд заасан ерөнхий боловсролын сургуульд хүүхэд элсүүлэх насны бүтцээр тооцсон гэдгийг тэмдэглэж байна.

Тиймээс 2000 болон 2010 оны тооллогын дүнгээр тооцсон бага боловсролын хамран сургалтын цэвэр жинг харьцуулах боломжгүй учир энэ бүлэгт 2000 оны тооллогын дүнгээр тооцсон бага боловсролын хамран сургалтын цэвэр жингийн үзүүлэлтийг оруулсангүй.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 97.4 хувь болж нэмэгдсэн нь Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа сурагчдын “Үдийн цай” хөтөлбөр, бага ангиудад сурах бичгийг төрөөс үнэгүй хангаж байгаагийн нөлөө гэж үзэж болно. Монгол улсын бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 2015 онд тавьсан зорилтод хүрэхэд 2.6 пунктээр дутуу байна.

Улаанбаатар хот, Төвийн болон Зүүн бүсэд бага боловсролын хамран сургалтын жин 2010 оны тооллогын дүнгээр хамгийн их буюу 98.0-аас дээш хувь байгаа бол Баруун бүсэд хамгийн бага буюу 95.4 хувь байна.

Хүснэгт 7. Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин, хувиар

	Суурь		Явц		Зорилт
	1995*	2000**	2005**	2010	2015
Улсын дундаж	97.5	95.0	93.3	97.4	100.0

Мэдээллийн эх үүсвэр:

*УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

** БСШУЯ. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын тайлан

Хүснэгт 8. Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин, бүс нутаг, аймаг, нийслэл, хүйс, хувиар, 2010 он

	БҮГД	Эрэгтэй	Эмэгтэй
Улсын дундаж	97.4	97.1	97.7
Баруун бүс	95.4	94.8	96.0
Баян-Өлгий	90.8	90.0	91.7
Говь-Алтай	98.1	97.9	98.4
Завхан	97.8	97.5	98.2
Увс	95.8	94.9	96.8
Ховд	97.0	96.7	97.3
Хангайн бүс	97.1	96.6	97.6
Архангай	96.9	96.3	97.5
Баянхонгор	97.0	96.5	97.6
Булган	97.7	97.4	98.1
Орхон	98.6	98.7	98.5
Өвөрхангай	96.5	95.7	97.3
Хөвсгөл	96.7	96.2	97.2
Төвийн бүс	98.0	97.7	98.3
Говьсүмбэр	98.3	97.9	98.7
Дархан-Уул	98.3	98.2	98.5
Дорноговь	98.1	97.8	98.5
Дундговь	98.2	98.0	98.4
Өмнөговь	98.2	97.9	98.6
Сэлэнгэ	97.8	97.5	98.1
Төв	97.4	97.0	97.9
Зүүн бүс	98.1	97.8	98.4
Дорнод	98.3	98.1	98.5
Сүхбаатар	97.5	97.1	98.0
Хэнтий	98.4	98.1	98.7
Улаанбаатар	98.1	98.0	98.3

Бага боловсролын хамран сургалтын цэвэр жинг аймгуудаар авч үзэхэд Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Дорнод, Хэнтий, Говь-Алтай аймгуудын бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 2010 оны тооллогын дүнгээр 98.0-аас дээш хувь байгаа бол Баян-Өлгий аймаг хамгийн бага буюу 90.8 хувь байна. Сургуульд хамрагдаагүй энэ насны хүүхдүүдийн 16.4 хувь нь зөвхөн Баян-Өлгий аймагт ногдож байна.

Бага боловсролын хамран сургалтын цэвэр жинг хүйсээр авч үзэхэд улсын дунджаар эрэгтэй хүүхдүүдийнх 97.1 хувь, эмэгтэй хүүхдүүдийнх 97.7 хувь болж зөрүү нь 0.6 пункт байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор 6-11 насны нийт 268703 хүүхэд тоологдсоноос эрэгтэй хүүхдийн тоо 136601, эмэгтэй хүүхдийн тоо 132102-д хүрч, эрэгтэй хүүхдийн тоо эмэгтэй хүүхдийн тооноос 4499 хүүхдээр буюу 3.4 хувиар илүү байна. 6-11 насны эрэгтэй, эмэгтэй хүүхдийн 6-11 насны нийт хүн амд эзлэх хувь улсын түвшинд 50.8 болон 49.2 хувь байна.


Хүснэгт 9. Бага боловсролын хамран сургалтын үзүүлэлтүүд, бүс нутаг, хүйс, хувиар, 2010 он

Бүс	Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин		6-11 насны нийт хүн амд эзлэх хувь		6-11 насны сургуульд суралцагчдын тоонд эзлэх хувь	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Улсын дундаж	97.1	97.7	50.8	49.2	50.7	49.3
Баруун бүс	94.8	96.0	50.8	49.2	50.5	49.5
Хангайн бүс	96.6	97.6	50.3	49.7	50.3	49.7
Төвийн бүс	97.7	98.3	50.5	49.5	50.5	49.5
Зүүн бүс	97.8	98.4	51.2	48.8	51.2	48.8
Улаанбаатар	98.0	98.3	50.9	49.1	50.9	49.1

Харин энэ насны сургуульд хамрагдсан хүүхдийн тоо 261720 болж, үүнээс эрэгтэй хүүхдүүдийн тоо 132601, эмэгтэй хүүхдүүдийн тоо 129119 болсон байна. 6-11 насны сургуульд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн хувийн жин 50.7 болон 49.3 хувь байна.

Дээрх хүснэгтээс харахад 6-11 насны нийт хүн амд эзлэх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн болон сургуульд хамрагдсан 6-11 насны хүүхдүүдийн дүнд эзлэх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн хувийн жин нь бараг тэнцүү байна.

Зураг 3. 6-11 насны нийт болон сургуульд суралцаж байгаа эрэгтэй, эмэгтэй хүүхдийн хүйсийн харьцаа, бүс нутаг, хувиар, 2010 он



6-11 насны нийт болон сургуульд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн хүйсийн харьцаа 1.03 байна. Энэ нь уг насны суралцагчдын хүйсийн харьцаа бараг тэгш байгааг илтгэн харуулж байна.

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэн эхэн үед сургуульд суралцагчдын хүйсийн харьцаа алдагдаж, ялангуяа эрэгтэй хүүхдүүд сургууль завсардах явдал ихээхэн гарч байсан билээ.

Монгол Улсын Засгийн газраас үлдсэн 5 жилийн хугацаанд энэ насны хүүхдүүдийг аль болох сургуульд бүрэн хамруулах үүднээс хамран сургалтын цэвэр жингээр хамгийн доогуур үзүүлэлттэй байгаа аймгууд болох Баян-Өлгий аймаг (90.8), Увс аймаг (95.8), Хөвсгөл аймаг (96.7)-т анхаарлыг голлон хандуулж, эдгээр аймгийн хүүхдүүдийг хуулиар сургуульд элсэх насанд нь аль болох бүрэн элсүүлэх явдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дээрх аймгуудад бага боловсролын хамран сургалтын цэвэр жин бусад аймгийг бодвол доогуур байгааг өрхийн амьжиргаа буюу ядууралтай холбон авч үзэж болохоор байна. Ядуу, нэн ядуу өрхүүд хүүхдүүдээ сургуульд хамруулахгүй орлого олох янз бүрийн хөдөлмөрт татан оролцуулж байж болно. Тухайлбал, 2000 оны ХАОСТ болон 2002-2003 оны ӨОЗС/АТТС-нд үндэслэн тооцсон ядуурлын тооцоогоор ядуурлын хамрах хүрээ Баян-Өлгий аймагт 43.4 хувь, Увс аймагт 46.7 хувь, Хөвсгөл аймагт 47.5 хувь байгаа нь улсын дунджаас (36.1 хувь) өндөр байна.

2.3 15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН БИЧИГ ҮСЭГ ТАЙЛАГДАЛТЫН ТҮВШИН

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ТООЦОХ АРГА ЗҮЙ

15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшин нь өдөр тутмын амьдралд богино хэмжээний өгүүлбэрийг уншиж, бичиж, ойлгох чадвартай 15-24 насны хүн амын тоог хувиар илэрхийлсэн үзүүлэлт болно. Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг **бичиг үсэг мэддэг хүн** гэж үзнэ. Харин аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших, бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг **бичиг үсэг мэддэггүй хүн** гэж үзнэ.

Энэ үзүүлэлт нь хүн амын боловсролын түвшинг илэрхийлж, бага боловсролын хамралтын байдал болон бага боловсролын үр ашгийг тооцоход ашиглагдана.

15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшинг бичиг үсэгт тайлагдсан 15-24 насны залуучуудын тоог тухайн насны нийт хүн амын тоонд харьцуулж тооцно.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Бичиг үсгийн мэдлэг нь хүний хөгжлийг илэрхийлдэг үндсэн үзүүлэлтүүдийн нэг билээ. Монгол улс нь бичиг үсэг тайлагдалтын түвшингээр бусад улс оронтой харьцуулахад нэлээд дээгүүр байранд ордог.

Манай улс 1921 оноос ард иргэдийнхээ бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах зорилтыг дэвшүүлж, энэ ажлын хүрээнд сургуулийн насны хүүхдийг сургуульд бүрэн хамруулах, улмаар боловсролыг шат дараалан зохих насанд нь эзэмшүүлэх, насанд хүрэгчдийн бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах талаар олон төрлийн арга хэмжээ авсан.

Үүний үр дүнд 1960-аад он гэхэд ард иргэдийн бичиг үсэг үл мэдэх явдлыг үндсэнд нь арилгасан тухайн үеийн цөөн орнуудын тоонд багтсан юм.

Монгол улсын хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшинг зөвхөн хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр тооцож байна. Хүн ам, орон сууцны 1989 оны тооллогын дүнгээр 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшин 99.0 хувьтай байсан бол 2000 оны тооллогоор 97.7 хувь болж, 1.3 пунктээр буурсан.

Харин хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр энэ үзүүлэлт 98.5 хувь болж, 2000 оны тооллогын дүнгээс 0.8 пунктээр нэмэгдсэн байна. Манай улс энэ үзүүлэлтээр 2015 оны зорилтдоо хүрэхэд 1.5 пункт дутуу байна.

Хүснэгт 10. Бичиг үсэг тайлагдалтын түвшин, хувиар

	Суурь		Явц		Зорилт
	1990*	2000	2005**	2010	2015
Улсын дундаж	99.0	97.7	97.7	98.5	100.0

Мэдээллийн эх үүсвэр: *ҮСХ. ХАОСТ-1989

** ҮСХ. ХАОСТ-2000

Тооллогоор 2010 онд манай улсад 15-24 насны 549.8 мянган залуучууд тоологдсон, үүний 541.2 мянга нь бичиг үсэгт тайлагдаж, харин 8.5 мянган энэ насны залуучууд бичиг үсэг мэддэггүй байна. Үүний 5.5 мянга нь эрэгтэйчүүд, 3.0 мянга нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 11. Бичиг үсэг тайлагдалтын түвшин, бүс нутаг, аймаг, нийслэл, хувиар, 2000, 2010 он

	2000	2010	Зөрүү
Улсын дундаж	97.7	98.5	0.8
Баруун бүс	97.0	97.3	0.3
Баян-Өлгий	98.1	97.8	-0.3
Говь-Алтай	96.9	97.7	0.7
Завхан	96.6	96.9	0.3
Увс	96.3	96.8	0.5
Ховд	96.9	97.5	0.5
Хангайн бүс	96.5	97.0	0.5
Архангай	96.1	96.1	0.0
Баянхонгор	95.8	96.7	0.9
Булган	97.0	98.1	1.0
Орхон	98.9	99.2	0.3
Өвөрхангай	95.7	96.3	0.6
Хөвсгөл	96.6	96.2	-0.5
Төвийн бүс	97.5	98.3	0.8
Говьсүмбэр	97.1	98.6	1.5
Дархан-Уул	99.1	99.3	0.2
Дорноговь	96.8	98.0	1.2
Дундговь	95.8	96.0	0.3
Өмнөговь	96.8	98.3	1.5
Сэлэнгэ	98.1	98.3	0.2
Төв	97.2	97.8	0.7
Зүүн бүс	95.1	95.9	0.8
Дорнод	95.7	97.2	1.5
Сүхбаатар	93.6	93.3	-0.3
Хэнтий	95.6	96.5	0.9
Улаанбаатар	99.5	99.5	0.1

Бичиг үсэг тайлагдалтын түвшинг 2000 болон 2010 оны тооллогын дүнгээр аймгийн түвшинд харьцуулан авч үзвэл Баян-Өлгий, Хөвсгөл, Сүхбаатар аймгуудаас бусад бүх аймаг, Улаанбаатар хотод бичиг үсэг тайлагдалтын түвшин нэмэгдсэн байна.

Харин дээрх 3 аймагт энэ үзүүлэлт 0.3-0.5 пунктээр буурсан байгаа нь 2000 онд буюу 10 жилийн өмнө бага боловсролын хамран сургалтын жин Баян-Өлгий аймагт улсын дунджаас 6.5 пункт, Хөвсгөл аймагт 4.4 пункт, Сүхбаатар аймагт 1.1 пунктээр доогуур байсантай холбон үзэж болох юм.

Бичиг үсэг тайлагдалтын түвшинг хот, хөдөөгөөр, хүйсээр авч үзэхэд хотод 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшин 99.3 хувь байгаа бол хөдөөд 96.0 хувь байна.

Хөдөөд бичиг үсэг үл мэдэгчид хотынхоос өндөр байгаа нь хөдөөгийн хүмүүсийн амьдралын хэвшил, эрхэлж байгаа аж ахуйтай нь холбоотой юм. Хөгжиж байгаа орнуудын жишгээр хөдөөгийн хүн амын боловсролын түвшин хотынхоос бага байдаг нь манай орны хувьд ч ижил байна.


Хүснэгт 12. Бичиг үсэг тайлагдалтын түвшин, бүс нутаг, хот, хөдөө, хүйс, хувиар, 2010 он

Бүс	Улсын түвшин			Хот			Хөдөө		
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Улсын дундаж	98.5	98.0	98.9	99.3	99.0	99.5	96.0	95.4	96.8
Баруун бүс	97.3	96.7	98.0	98.7	98.2	99.2	96.3	95.8	97.0
Хангайн бүс	97.0	96.4	97.7	98.6	98.2	99.0	95.5	94.9	96.4
Төвийн бүс	98.3	97.8	98.8	99.0	98.8	99.3	97.4	96.9	98.1
Зүүн бүс	95.9	94.9	97.0	98.0	97.3	98.7	93.9	92.9	95.2
Улаанбаатар	99.5	99.4	99.7	99.5	99.4	99.7	-	-	-

15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшинг бүсээр, хүйсээр авч үзэхэд аль ч бүсэд энэ насны эрэгтэйчүүдийн бичиг үсэг тайлагдалтын түвшин эмэгтэйчүүдийнхээс доогуур байна.

Улсын түвшинд 15-24 насны эрэгтэйчүүдийн бичиг үсэг тайлагдалтын түвшин 98.0 хувь, эмэгтэйчүүдийнх 98.9 хувь байна. Хотод 15-24 насны эрэгтэйчүүдийн бичиг үсэг тайлагдалтын түвшин 99.0 хувь, эмэгтэйчүүдийнх 99.5 хувьтай байгаа бол хөдөөд эрэгтэйчүүдийнх 95.4 хувь, эмэгтэйчүүдийнх 96.8 хувь байна.

Зураг 4. Бичиг үсэг тайлагдалтын түвшин, бүс нутаг, хүйс, хувиар, 2010 он



15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшингээр Улаанбаатар хот (99.5), Дархан-Уул (99.3), Орхон (99.2) аймгууд хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа бол Сүхбаатар (93.3), Дундговь (96.0), Архангай (96.1), Хөвсгөл (96.2), Өвөрхангай (96.3) аймгууд хамгийн доогуур үзүүлэлттэй байна. Хамгийн өндөр үзүүлэлттэй Улаанбаатар хот, хамгийн доогуур үзүүлэлттэй Сүхбаатар аймгийн 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшний ялгаа 6.3 пункт байна.



Хрмррд твр зрхэм. Тлрд хрмррн эрдэнэ



3

ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ
ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ
ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ
НЭМЭГДҮҮЛЭХ

ЗОРИЛГО ГУРАВ. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ

ЗОРИЛТ 6: 2009 ОН ГЭХЭД БАГА БОЛОН ДУНД
БОЛОВСРОЛ ЭЗЭМШИГЧДИЙН ДУНД, 2015 ОН
ГЭХЭД БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД
СУРАЛЦАГЧДЫН ХҮЙСИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААГ
ХАНГАХ

ҮЗҮҮЛЭЛТ:

3.1 Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн
тооны харьцаа

3.2 Дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн
тооны харьцаа

3.1 БАГА БОЛОВСРОЛ ЭЗЭМШИЖ БАЙГАА ОХИД, ХӨВГҮҮДИЙН ТООНЫ ХАРЬЦАА

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ТООЦОХ АРГА ЗҮЙ

Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тооны харьцаа нь бага шатны боловсролын сургуульд элссэн эмэгтэй хүүхдийн тоог эрэгтэй хүүхдийн тоонд харьцуулсан харьцаа юм.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Улс орны хөгжил, дэвшилд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх тэгш оролцоог хангаж, тэднийг нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх нь хүн амын амьдралын чанарыг сайжруулах, нийгэм дэх сөрөг үзэгдлийг арилгахад ач холбогдолтой.

Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тооны харьцааг Хүн ам, орон сууцны тооллогын мэдээллээр анх удаа гаргаж байна. Ингэхдээ дээрх аргачлалын дагуу тооллогын асуулгын хуудсанд тусгагдсан 14 дүгээр асуулт болох “Та одоо сургуульд сурдаг (цэцэрлэгт хүмүүждэг үү) уу” болон зөвхөн 6 ба түүнээс дээш насны хүнээс асуусан 15 дугаар асуулт болох “Та эзэмшсэн боловсролынхоо дээд түвшинг хэлнэ үү” гэсэн 2 асуултад үндэслэн шууд бус аргаар тооцооллоо. Тиймээс бага сургуульд одоо сурч байгаа 6-гаас доош насны болон 12, түүнээс дээш насны хүүхэд энд хамрагдаагүй болохыг тэмдэглэж байна.

БСШУЯ-ны захиргааны статистикийн мэдээллээр бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа 2000 онд 1.01 хувь байна. Нэгэнт энэхүү сэдэвчилсэн танилцуулгад тооллогын мэдээллээр тооцсон МХЗ-ын шалгуур үзүүлэлтийг авч үзэж байгаа тул Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын мэдээллийн санг ашиглан дээр дурдсан шууд бус аргаар бага боловсрол эзэмшиж байгаа охид хөвгүүдийн харьцааг тооцоолоход БСШУЯ-ны мэдээлэлтэй ижил үр дүн гарч байна. Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдэд 8-11 насны хүүхдүүдийг хамруулсан болно.

Хүснэгт 13. Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа

	Суурь		Явц		Зорилт
	1995*	2000	2005*	2010	2015
Улсын дундаж	1.03	1.01	0.98	0.97	1.0

Мэдээллийн эх үүсвэр: * БСШУЯ. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын тайлан

Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа 1995 онд 1.03 байсан бол 2000 онд 1.01, 2005 онд 0.98, 2010 онд 0.97 болж буурчээ. Өөрөөр хэлбэл, бага боловсрол эзэмшиж байгаа охидын тоо хөвгүүдийн тооноос өндөр байсан бол сүүлийн жилүүдэд хөвгүүдийн тоо нь охидын тооноос илүү болсон байна. Монгол улс 2015 онд энэ үзүүлэлтийг 1.0 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн бөгөөд зорилтдоо хүрэхэд 0.03-хан пункт дутуу байна.

Хүснэгт 14. Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тоо, харьцаа, бүс нутаг, аймаг, нийслэлээр, 2000, 2010 он

Аймаг, бүс	2000			2010		
	Харьцаа	Охидын тоо	Хөвгүүдийн тоо	Харьцаа	Охидын тоо	Хөвгүүдийн тоо
БҮГД	1.01	103 458	102 425	0.97	113 153	117 196
Баруун бүс	0.99	18 443	18 626	0.97	19 853	20 399
Баян-Өлгий	1.01	3 921	3 867	1.00	5 224	5 228
Говь-Алтай	0.97	2 873	2 970	0.97	2 981	3 087
Завхан	0.98	3 590	3 651	0.93	3 219	3 469
Увс	0.99	3 975	4 028	0.97	4 180	4 319
Ховд	0.99	4 084	4 110	0.99	4 249	4 296
Хангайн бүс	1.03	24 718	24 019	0.98	24 488	25 022
Архангай	1.04	4 305	4 144	0.96	3 949	4 114
Баянхонгор	1.02	4 251	4 167	1.02	3 941	3 876
Булган	1.05	2 879	2 749	0.91	2 221	2 452
Орхон	0.98	3 274	3 348	0.97	3 638	3 746
Өвөрхангай	1.04	5 049	4 834	0.98	5 126	5 243
Хөвсгөл	1.04	4 960	4 777	1.00	5 613	5 591
Төвийн бүс	1.00	21 136	21 078	0.97	19 517	20 083
Говьсүмбэр	0.99	612	618	0.98	588	600
Дархан-Уул	0.93	3 860	4 133	0.97	3 512	3 628
Дорноговь	1.10	2 451	2 223	1.03	2 777	2 698
Дундговь	1.03	2 325	2 250	0.95	1 891	1 992
Өмнөговь	0.99	2 173	2 197	0.97	2 567	2 654
Сэлэнгэ	0.96	4 902	5 081	0.97	4 566	4 717
Төв	1.05	4 813	4 576	0.95	3 616	3 794
Зүүн бүс	1.02	9 249	9 074	0.94	8 803	9 324
Дорнод	1.01	3 379	3 357	0.94	2 876	3 068
Сүхбаатар	1.02	2 605	2 545	0.95	2 499	2 639
Хэнтий	1.03	3 265	3 172	0.95	3 428	3 617
Улаанбаатар	1.01	29 912	29 628	0.96	40 492	42 368

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын үед улсын хэмжээнд 103.4 мянган охид, 102.4 мянган хөвгүүд бага шатны боловсролын сургуульд хамрагдаж байсан бол 2010 оны тооллогын үед 113.5 мянган охид, 117.2 мянган хөвгүүд бага шатны боловсролын сургуульд хамрагдсан байна.

Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа улсын түвшинд 2010 онд 2000 оныхоос 0.04 пунктээр, Баруун бүсэд 0.02 пунктээр, Хангайн бүсэд 0.05 пунктээр, Төвийн бүсэд 0.03 пунктээр, Зүүн бүсэд 0.08 пунктээр, Улаанбаатар хотод 0.05 пунктээр буурсан байна.

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО: МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ЗАРИМ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Энэ үзүүлэлтийг аймгийн түвшинд авч үзэхэд Дархан-Уул, Сэлэнгэ аймагт бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа 2010 онд 2000 оныхоос 0.01-0.04 пунктээр нэмэгдсэн бол Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймагт энэ үзүүлэлт өмнөх тооллогын түвшинд байна. Харин бусад аймагт уг үзүүлэлт 0.01-0.14 пунктээр буурчээ.

Хүснэгт 15. Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа, бүс нутаг, хот, хөдөөгөөр, 2010 он

Бүс	Улсын түвшин	Хот	Хөдөө
Улсын дундаж	0.97	0.97	0.96
Баруун бүс	0.97	1.00	0.96
Хангайн бүс	0.98	0.99	0.97
Төвийн бүс	0.97	0.97	0.97
Зүүн бүс	0.94	0.95	0.94
Улаанбаатар	0.96	0.96	-

Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа 2010 онд хот, хөдөөд адилхан байна. Энэ үзүүлэлт Хангайн бүсэд хамгийн өндөр 0.97, Зүүн бүсэд хамгийн бага 0.94 байна. Түүнчлэн Баруун бүсийн хот, суурин газарт энэ харьцаа 1.00 болж, 2015 оны зорилтдоо хүрсэн байна. Зүүн бүсийн хот, хөдөөд бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа хоёулаа улсын дунджаас доогуур байна.

3.2 ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШИЖ БАЙГАА ОХИД, ХӨВГҮҮДИЙН ТООНЫ ХАРЬЦАА

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ТООЦОХ АРГА ЗҮЙ

Дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тооны харьцаа нь дунд шатны боловсролын сургуульд элссэн эмэгтэй, эрэгтэй хүүхдийн тооны харьцаа юм.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тооны харьцааг мөн Хүн ам, орон сууцны тооллогын мэдээллээр анх удаа гаргаж байна. Ингэхдээ бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тооны харьцааг тооцсоны адилаар тооллогын асуулгын хуудсанд тусгагдсан 14 дүгээр асуулт болох “Та одоо сургуульд сурдаг (цэцэрлэгт хүмүүждэг үү) уу ” болон зөвхөн 6 ба түүнээс дээш насны хүнээс асуусан 15 дугаар асуулт болох “Та эзэмшсэн боловсролынхоо дээд түвшинг хэлнэ үү” гэсэн 2 асуултад үндэслэн шууд бус аргаар тооцооллоо. БСШУЯ-ны захиргааны статистикийн мэдээллээр дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа 2000 онд 1.20 хувь байна. Дээр дурдсанаар энэхүү сэдэвчилсэн танилцуулгад нэгэнт тооллогын мэдээллээр тооцсон МХЗ-ын шалгуур үзүүлэлтийг авч үзэж байгаа тул Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын мэдээллийн санг ашиглан дунд боловсрол эзэмшиж байгаа охид хөвгүүдийн харьцааг шууд бус аргаар тооцоолоход 1.14 гэсэн үр дүн гарлаа. Энэ нь БСШУЯ-ны мэдээллээс 0.06 пунктээр доогуур байна.

Хүснэгт 16. Дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа

	Суурь		Явц		Зорилт
	1995*	2000	2005*	2010	2015
Улсын дундаж	1.12	1.14	1.11	1.02	1.0

Мэдээллийн эх үүсвэр: * БСШУЯ. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын тайлан

Дунд шатны боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа 1995 онд 1.12 байсан бол 2000 онд 1.14, 2005 онд 1.11, 2010 онд 1.02 болж буурсан нь бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаатай адил зүй тогтолтой байна. Монгол улс 2015 онд энэ үзүүлэлтийг 1.0 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн бөгөөд зорилтыг хангах боломжтой гэж дүгнэж болохоор байна.

Хүснэгт 17. Дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тоо, тэдний харьцаа, бүс нутаг, аймаг, нийслэлээр, 2000, 2010 он

Аймаг, бүс	2000			2010		
	Харьцаа	Охидын тоо	Хөвгүүдийн тоо	Харьцаа	Охидын тоо	Хөвгүүдийн тоо
БҮГД	1.14	137 032	120 072	1.02	142 177	139 109
Баруун бүс	1.17	22 359	19 051	1.05	24 857	23 614
Баян-Өлгий	1.07	4 784	4 474	1.06	5 996	5 681
Говь-Алтай	1.19	3 359	2 830	1.04	3 275	3 149
Завхан	1.19	5 082	4 272	1.01	4 258	4 232
Увс	1.27	4 238	3 333	1.10	5 669	5 157
Ховд	1.18	4 896	4 142	1.05	5 659	5 395
Хангайн бүс	1.23	29 640	24 185	1.05	32 409	30 744
Архангай	1.26	5 304	4 209	1.08	5 487	5 099
Баянхонгор	1.19	4 005	3 359	1.06	4 949	4 648
Булган	1.22	3 621	2 978	1.01	3 323	3 304
Орхон	1.13	5 590	4 959	1.00	5 101	5 112
Өвөрхангай	1.34	4 988	3 729	1.06	6 301	5 961
Хөвсгөл	1.24	6 132	4 951	1.09	7 248	6 620
Төвийн бүс	1.18	26 689	22 630	1.00	24 636	24 640
Говьсүмбэр	1.21	813	670	0.85	769	910
Дархан-Уул	1.10	5 469	4 981	0.99	5 236	5 286
Дорноговь	1.23	2 857	2 329	1.06	3 130	2 946
Дундговь	1.40	2 679	1 918	1.01	2 513	2 491
Өмнөговь	1.32	2 596	1 964	1.00	2 959	2 956
Сэлэнгэ	1.13	6 628	5 855	1.01	5 338	5 295
Төв	1.15	5 647	4 913	0.99	4 691	4 756
Зүүн бүс	1.19	11 380	9 539	1.00	10 770	10 761
Дорнод	1.18	4 674	3 966	1.01	4 086	4 053
Сүхбаатар	1.18	2 671	2 256	1.05	2 879	2 754
Хэнтий	1.22	4 035	3 317	0.96	3 805	3 954
Улаанбаатар	1.05	46 964	44 667	1.00	49 505	49 350


Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын үед улсын хэмжээнд 137.0 мянган охид, 120.1 мянган хөвгүүд дунд шатны боловсролын сургуульд хамрагдаж байсан бол 2010 оны тооллогын үед 142.2 мянган охид, 139.1 мянган хөвгүүд дунд шатны боловсролын сургуульд хамрагдсан байна.

Дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа улсын түвшинд 2010 онд 2000 оныхоос 0.12 пунктээр, Баруун бүсэд 0.12 пунктээр, Хангайн бүсэд 0.17 пунктээр, Төвийн бүсэд 0.18 пунктээр, Зүүн бүсэд 0.19 пунктээр, Улаанбаатар хотод 0.05 пунктээр буурсан байна.

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО: МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ЗАРИМ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Энэ үзүүлэлтийг аймгийн түвшинд авч үзэхэд Дундговь аймагт дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа 2010 онд 2000 оныхоос хамгийн их буюу 0.39 пунктээр буурсан бол Баян-Өлгий аймагт хамгийн бага 0.01 пунктээр буурчээ.

Зураг 5. Дунд шатны боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа, бүс нутаг, хот, хөдөөгөөр, 2010 он



Дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа хот, хөдөөд ижил байна. Дунд боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа Хангайн болон Баруун бүсэд 1.05 байгаа бол Төвийн болон Зүүн бүс, Улаанбаатар хотод 1.00 болж зорилтот түвшинд хүрсэн байна.

Төвийн болон Зүүн бүсийн хөдөөд энэ харьцаа 0.99 болон 0.97-тэй байгаа бол бусад бүсэд энэ харьцаа 1.00 болон түүнээс дээш байна.



Хрмррд твр зрхэм. Тлрд хрмррн эрдэнэ

ЗОРИЛТ 7: ЦАЛИНТАЙ АЖИЛ ЭРХЭЛЖ БАЙГАА ХҮН АМЫН
ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ

ҮЗҮҮЛЭЛТ:

*3.4 ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа
хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь*

3.4 ХАА-ГААС БУСАД САЛБАРТ ЦАЛИНТАЙ АЖИЛ ЭРХЭЛЖ БАЙГАА ХҮН АМД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ТООЦОХ АРГА ЗҮЙ

Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь нь хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дунд энэ салбаруудад цалинтай ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн тоог хувиар илэрхийлсэн үзүүлэлт болно. Хөдөө аж ахуйн бус салбарт аж үйлдвэр, барилга болон үйлчилгээг хамруулна.

Уг үзүүлэлт нь хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдэд хөдөлмөрийн зах зээлийг хэр нээлттэй байгааг харуулах бөгөөд зөвхөн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломж бус мөн хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдал, эдийн засгийн үр ашиг, өөрчлөлтөд дасан зохицох чадварыг илэрхийлнэ. Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад өрхийн бизнест цалин хөлсгүй оролцох, албан бус секторт хамрагдах нь илүү түгээмэл байдаг.

ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг ХАА-н бус салбарт цалинтай ажиллагч эмэгтэйчүүдийн тоог ХАА-н бус салбарт цалинтай ажиллагчдын тоонд харьцуулж тооцно.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улс жендерийн тэнцвэртэй байдлыг хамгаалсан хууль, эрх зүйн тогтолцоог бүрдүүлж байна. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах төрийн бодлогыг Монгол улсын “Үндсэн хууль”, “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль” болон бусад хуулиудад тусган хэрэгжүүлж байна.

ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2005 онд 53.1 байгаа нь 1990 оныхоос 2.0 пунктээр, 1995 оныхоос 5.2 пунктээр, 2000 оныхоос болон 5.4 пунктээр тус тус дээгүүр байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр ХАА-н бус салбарт цалинтай ажиллагчдын тоо 670.6 мянга, үүнээс эмэгтэй ажиллагчдын тоо 315.0 мянгад хүрч, энэ үзүүлэлт өмнөх онуудын түвшнээс нэлээд буурч, 47.0 хувьд хүрсэн байна.

Хүснэгт 18. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь

	Суурь		Явц			Зорилт
	1990*	1995*	2000	2005*	2010	2015
Улсын дундаж	51.1	47.9	47.7	53.1	47.0	50.0

Мэдээллийн эх үүсвэр: * ҮСХ. Хүн амын ажил эрхлэлтийн жилийн тайлан

Дээрх хүснэгтэд харуулсан хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн 1990-2005 оны гүйцэтгэл нь “Хүн амын ажил эрхлэлтийн жилийн тайлан”-гаас тооцсон үзүүлэлт юм. Жил

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО: МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ЗАРИМ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

бүрийн динамик тасралтгүй байх, харьцуулалт хийх үүднээс энэ тайлангаар тооцсон үр дүнг албан ёсны үзүүлэлт болгон авч байсан.

Энэхүү сэдэвчилсэн танилцуулгад Хүн ам, орон сууцны тооллогын үр дүнгээр тооцсон МХЗ-ын үзүүлэлтийг авч үзэж байгаа тул 2000 оны тооллогын мэдээллийн санг ашиглан хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг тооцож 2010 оны тооллогын үр дүнтэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 19. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, бүс нутаг, аймаг, нийслэлээр, 2000, 2010 он

Аймаг, бүс	2000			2010		
	ХАА-н бус салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүний тоо	Үүнээс: Эмэгтэйчүүдийн тоо	Эзлэх хувь	ХАА-н бус салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүний тоо	Үүнээс: Эмэгтэйчүүдийн тоо	Эзлэх хувь
Улсын дундаж	401 925	191 570	47.7	670 647	314 974	47.0
Баруун бүс	37 805	16 994	45.0	53 192	25 740	48.4
Баян-Өлгий	7 390	2 913	39.4	10 452	4 911	47.0
Говь-Алтай	6 164	2 979	48.3	9 252	4 404	47.6
Завхан	7 679	3 796	49.4	10 189	5 198	51.0
Увс	8 013	3 574	44.6	11 717	5 571	47.5
Ховд	8 559	3 732	43.6	11 582	5 656	48.8
Хангайн бүс	59 235	28 429	48.0	88 448	43 747	49.5
Архангай	7 267	3 598	49.5	9 690	5 134	53.0
Баянхонгор	7 173	3 634	50.7	11 604	5 913	51.0
Булган	6 230	3 156	50.7	8 160	4 091	50.1
Орхон	18 306	8 474	46.3	28 071	13 114	46.7
Өвөрхангай	10 153	4 758	46.9	15 477	7 632	49.3
Хөвсгөл	10 106	4 809	47.6	15 446	7 863	50.9
Төвийн бүс	74 532	34 386	46.1	109 640	47 344	43.2
Говьсүмбэр	2 652	1 227	46.3	3 916	1 768	45.1
Дархан-Уул	19 679	9 438	48.0	25 951	12 100	46.6
Дорноговь	10 976	4 577	41.7	16 292	7 071	43.4
Дундговь	4 450	2 326	52.3	6 434	3 237	50.3
Өмнөговь	6 211	2 778	44.7	21 625	6 481	30.0
Сэлэнгэ	17 062	8 021	47.0	21 056	9 886	47.0
Төв	13 502	6 019	44.6	14 366	6 801	47.3
Зүүн бүс	24 284	11 340	46.7	33 218	16 047	48.3
Дорнод	10 079	4 608	45.7	13 837	6 734	48.7
Сүхбаатар	5 338	2 357	44.2	7 717	3 593	46.6
Хэнтий	8 867	4 375	49.3	11 664	5 720	49.0
Улаанбаатар	206 069	100 421	48.7	386 149	182 096	47.2

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээр хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа нийт хүн амын тоо 401.9 мянга, үүний дотор эмэгтэй ажиллагчдын тоо 191.6 мянга, эмэгтэйчүүдийн эзлэх хувь улсын түвшинд 47.7 хувь байсан. Харин 2010 оны тооллогын дүнгээр ХАА-гаас бусад салбарт ажил эрхэлж байгаа хүний тоо 670.6 мянга болж, 2000 оныхоос 268.7 мянган хүнээр буюу 66.9 хувиар нэмэгдсэн бол үүний дотор эмэгтэй ажиллагчдын тоо 315.0 болж, өмнөх тооллогын үеийнхээс 123.4 мянган хүнээр буюу 64.4 хувиар дээгүүр байна. Эмэгтэйчүүдийн эзлэх хувь 47.0 болж, 2000 оны тооллогынхоос 0.7 пунктээр буурлаа.

ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2010 онд 2000 оныхоос Баруун, Хангай, Зүүн бүсэд 1.5-3.4 пунктээр нэмэгдсэн бол харин Төвийн бүс болон Улаанбаатар хотод 1.6-3.0 пунктээр буурсан байна.


Энэ үзүүлэлт Өмнөговь аймагт хамгийн бага буюу 30.0 хувь болж өмнөх тооллогын үеийнхээс 14.8 пунктээр буурчээ. Хэдийгээр Өмнөговь аймаг нь ажиллах хүчний оролцоо хамгийн өндөртэй, ажилгүйдлийн түвшин багатай аймаг хэдий ч аймгийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тооны зөрүү их байгаагаас дээрх үзүүлэлт хамгийн бага байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр Өмнөговь аймаг хөдөлмөрийн насны нийт хүн амын 40.4 хувь нь, эдийн засгийн идэвхтэй хүн амын 34.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Өмнөговь аймгийн хөдөлмөрийн насны хүн ам 2010 онд 2000 оныхоос 13.1 мянгаар нэмэгдсэний 11.2 мянга буюу 85.4 хувь нь эрэгтэйчүүд, эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 11.4 мянгаар нэмэгдсэний 10.1 мянга буюу 89.0 хувь нь эрэгтэйчүүд байна. Ийнхүү эрэгтэйчүүдийн тоо ихээхэн нэмэгдэж байгааг уг аймагт хэрэгжиж байгаа Оюу Толгой төслийн үйл ажиллагаатай холбон тайлбарлаж болох юм.

ХАА-н бус салбарт цалинтай ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувийг бүсүүдээр авч үзэхэд 2010 онд Хангайн бүсэд ХАА-н бус салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн их 49.5 хувь байгаа бол Төвийн бүсийнх хамгийн бага 43.2 хувь байна. Төвийн бүсэд ХАА-н бус салбарт ажиллаж байгаа эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс 13.6 пунктээр дээгүүр байна.

Аймгуудаар авч үзэхэд Завхан, Архангай, Баянхонгор, Булган, Хөвсгөл, Дундговь аймгуудад ХАА-н бус салбарт цалинтай ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь 50-аас дээш байна.

Зураг 6. ХАА-н бус салбарт цалинтай ажил эрхэлж байгаа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн харьцаа, бүс нутаг, хувиар, 2010 он



ХАА-гаас бусад салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд эмэгтэйчүүд боловсруулах үйлдвэрлэл, бөөний болон жижиглэн худалдаа, зочид буудал, зоогийн газар, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэндийн салбарт түлхүү ажиллаж байна.

Хүснэгт 20. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2000, 2010 он

	2000	2010
БҮГД	100.0	100.0
Уул уурхай, олборлолт	2.4	3.1
Боловсруулах үйлдвэрлэл	16.1	9.5
Цахилгаан, хий, уур, усан хангамж	2.1	2.0
Барилга	1.8	3.8
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	18.4	20.8
Зочид буудал, зоогийн газар	4.1	7.0
Тээвэр ба агуулахын аж ахуй, холбоо, хуурай замын тээвэр	6.2	5.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.4	3.1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	2.5	1.4
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	8.6	10.8
Боловсрол	19.1	18.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	12.8	9.1
Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйл ажиллагаа	4.2	4.8
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.1	0.2
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	0.2	0.5



Хрмррд твр зрхэм. Тлрд хрмррн эрдэнэ



БАЙГАЛЬ ОРЧНЫ
ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ

ЗОРИЛГО ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

ЗОРИЛТ 16: 2015 ОН ГЭХЭД БАТАЛГААТ УНДНЫ УСНЫ
ХАНГАМЖГҮЙ, САЙЖРУУЛСАН АРИУН ЦЭВРИЙН
БАЙГУУЛАМЖИД ХАМРАГДААГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ
ХУВИЙГ БУУРУУЛАХ

ҮЗҮҮЛЭЛТ:

7.8 *Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь*

7.8 БАТАЛГААТ УНДНЫ УСНЫ ХАНГАМЖГҮЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ТООЦОХ АРГА ЗҮЙ

Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь нь нийт хүн амын дунд төвлөрсөн болон төвлөрсөн бус усан хангамж, хамгаалагдсан худаг, булаг шанднаас ундны усаа авч хэрэглэж чадахгүй байгаа хүн амын тоог хувиар илэрхийлсэн үзүүлэлт бөгөөд энэ нь баталгаат ундны усны хангамжийг сайжруулах бодлого боловсруулахад ашиглагдана. Баталгаагүй ундны ус нь олон төрлийн өвчнийг үүсгэх эх үүсвэр болно.

Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувийг баталгаат ундны усны хангамжгүй хүн амын тоог тухайн жилийн хүн амын дундаж тоонд харьцуулж тооцно.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улс нь усны нөөцөөр хүрэлцээтэй орны тоонд ордог. Гэвч гадаргын болон гүний усны хуваарилалт Монгол орны нутаг бүрт харилцан адилгүйгээс усны дутагдал байнга гардаг байна. Тухайлбал: говь, тал хээрийн бүсүүдэд ундны цэвэр усны хангамж дутагдалтай байсаар байна.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр Монгол улсын хүн амын 27.4 хувь нь төвлөрсөн болон төвлөрсөн бус усан хангамж, хамгаалагдсан худаг, булаг шанднаас ундны усаа авч хэрэглэж чадахгүй байна.

Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын тоог тооллогын орон сууцны асуулгын хуудсанд тусгагдсан 11 дүгээр асуулт болох “Танай ундны усны эх үүсвэр юу вэ” гэсэн асуултад зөөврийн ус болон гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг шанд гэж хариулсан хүн амын тоон дээр үндэслэн тооцов.

Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь 2000 онд 33.8 хувь, 2005 онд 28.4 хувь байсан бол 2010 онд 27.4 хувь болж 2000 оныхоос 6.4, 2005 оныхоос 1.0 пунктээр буурсан байна.

Хүснэгт 21. Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь

	Явц		Зорилт	
	2000	2005*	2010	2015
Улсын дундаж	33.8	28.4	27.4	40.0

Мэдээллийн эх үүсвэр: * УСГ. Хүүхэд хөгжил түүвэр судалгаа - 2005

Тооллогын дүнгээр Монгол улсын нийт хүн амын 23.5 хувь нь төвлөрсөн усан хангамжийн системээс, 12.4 хувь нь төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байрнаас, 16.4 хувь нь хамгаалагдсан худаг, булаг, шанднаас, 0.1 хувь нь цэвэршүүлэн савласан уснаас, 20.3 хувь нь төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байрнаас ундны усаа авч хэрэглэж байгаа бол 6.2 хувь нь зөөврийн уснаас, 21.2 хувь нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанднаас ундны усаа авч хэрэглэж байна. Нийт хүн амын 72.6 хувь нь баталгаат ундны усны хангамжтай байна.

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО: МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ЗАРИМ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Хүснэгт 22. Хүн амын ундны усны эх үүсвэр, бүс нутгаар, 2010 он

	Улсын дундаж	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар хот
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн систем	23.4	4.8	9.0	21.1	14.6	37.8
Төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр	12.4	0.9	0.4	9.7	16.3	21.6
Хамгаалагдсан худаг, булаг, шанд	16.4	27.7	22.6	26.2	29.0	4.5
Цэвэршүүлэн савласан ус	0.1	0.0	0.0	0.3	0.0	0.0
Төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр	20.3	1.8	19.8	9.3	5.3	32.7
Зөөврийн ус	6.2	7.2	8.9	10.7	6.8	2.9
Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд	21.2	57.6	39.3	22.7	28.0	0.5

Улсын дунджаар 2010 онд хотын хүн амын 10.6 хувь, хөдөөгийн хүн амын 63.1 хувь нь баталгаат ундны усны хангамжгүй байна. Улаанбаатар хотыг оруулахгүйгээр хотод баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь Баруун бүсэд хамгийн их 46.0 хувь байгаа бол Зүүн бүсэд хамгийн бага 10.8 хувь байна.

Харин хөдөөд баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь мөн адил Баруун бүсэд хамгийн өндөр 74.8 хувь байгаа бол Төвийн бүсэд хамгийн бага 46.1 хувь байна.

Зураг 7. Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь, бүс нутаг, хот, хөдөөгөөр, 2010 он



Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувийг бүсээр авч үзэхэд Баруун бүсийн хүн амын 64.8 хувь, Хангайн бүсийн хүн амын 48.2 хувь, Төвийн бүсийн хүн амын 33.3 хувь, Зүүн бүсийн хүн амын 34.8 хувь, Улаанбаатар хотын хүн амын 3.4 хувь нь баталгаат ундны усны эх үүсвэрээс усаа авч хэрэглэж чадахгүй байна.

Хүснэгт 23. Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь, бүс нутаг, аймаг, нийслэлээр, 2000, 2010 он

	2000	2010	Зөрүү
Улсын дундаж	33.8	27.4	-6.4
Баруун бүс	62.8	64.8	2.0
Баян-Өлгий	64.7	86.5	21.8
Говь-Алтай	48.5	63.4	14.9
Завхан	75.9	63.5	-12.4
Увс	65.9	50.2	-15.7
Ховд	53.1	56.2	3.1
Хангайн бүс	57.5	48.2	-9.3
Архангай	78	61.9	-16.1
Баянхонгор	53.4	69.8	16.4
Булган	59.9	53.3	-6.6
Орхон	9.9	5.5	-4.4
Өвөрхангай	59.1	43.3	-15.8
Хөвсгөл	69.1	58.4	-10.7
Төвийн бүс	17.5	33.3	15.8
Говьсүмбэр	15.5	34.8	19.3
Дархан-Уул	7.4	10.4	3.0
Дорноговь	10.8	33.5	22.7
Дундговь	6.1	43.7	37.6
Өмнөговь	9.0	35.4	26.4
Сэлэнгэ	24.5	48.3	23.8
Төв	32.7	34.4	1.7
Зүүн бүс	35.1	34.8	-0.3
Дорнод	22.7	30.8	8.1
Сүхбаатар	33.6	43.0	9.4
Хэнтий	48.4	32.6	-15.8
Улаанбаатар	7.5	3.4	-4.1

Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувийг, аймгаар, бүсээр, 2000 болон 2010 оны тооллогын дүнгээр харьцуулж үзэхэд Баруун болон Төвийн бүсийн баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь 2010 онд 2000 оноос 2.0 болон 15.8 пунктээр нэмэгдсэн бол харин бусад бүсэд 0.3-9.3 пунктээр буурсан байна.

Энэ үзүүлэлтийг аймгаар авч үзэхэд Баян-Өлгий (21.8), Ховд (3.1), Говь-Алтай (14.9), Баянхонгор (16.4), Говьсүмбэр (19.3), Дархан-Уул (3.0), Дорноговь (22.7), Дундговь (37.6), Өмнөговь (26.4), Сэлэнгэ (23.8), Төв (1.7), Дорнод (8.1), Сүхбаатар (9.4) аймагт нэмэгдэж, харин Завхан (-12.4), Увс (-15.7), Архангай (-16.1), Булган (-6.6), Орхон (-4.4), Өвөрхангай (-15.8), Хөвсгөл (-10.7), Хэнтий (-15.8) аймаг, Улаанбаатар (-4.1) хотод буурсан байна.

Хэдийгээр улсын түвшинд баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь 2010 онд 2000 оныхоос буурсан хэдий ч нийт 13 аймгийн түвшинд энэ үзүүлэлт нэмэгдсэн байна.

Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах хүрээнд төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хот, суурин газрын ус хангамжийн тоног төхөөрөмж, барилга байгууламжийг өргөтгөх, сэргээн засварлах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, байгалийн усны нөөцийг үр ашигтай ашиглах шаардлагатай байна.



Хрмррд твр зрхэм. Тлрд хрмррн эрдэнэ

**ЗОРИЛТ 17: 2015 ОН ГЭХЭД ХҮН АМЫН ОРОН СУУЦНЫ НӨХЦЛИЙГ
САЙЖРУУЛАХ**

ҮЗҮҮЛЭЛТ:

*7.10 Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч
байгаа хүн амын эзлэх хувь*

7.10 ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭТЭЙ ОРОН СУУЦАНД АМЬДАРЧ БАЙГАА ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ТООЦОХ АРГА ЗҮЙ

Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь нь нийт хүн амаас төвлөрсөн шугам сүлжээ бүхий орон сууцанд амьдарч байгаа хүн амын тоог хувиар илэрхийлсэн үзүүлэлт болно. Төвлөрсөн шугам сүлжээ гэж хот, суурин газрын хүн амыг цэвэр ус, дулаан, цахилгаанаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга, байгууламжийг ойлгоно. Шугам сүлжээ гэсэн ойлголтод цэвэр ус дамжуулах, хуваарилах, хэрэглэгчдэд хүргэх, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах байгууламжийг хамааруулна.

Энэ үзүүлэлт нь хүн амын эрүүл ахуйн шаардлага хангасан сууцны хангамжийн түвшинг илэрхийлж, хот, суурингийн агаарын бохирдол, хүн амын дундах халдварт өвчний дэгдэлт, өвчлөлөөс сэргийлэх зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөлийн нэг нь болно.

Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувийг инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын тоог жилийн эцсийн хүн амын тоонд харьцуулж тооцно.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улс 2015 он гэхэд эрүүл ахуйн шаардлага хангасан орон сууц буюу инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувийг 30.0 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлсэн. Манай улсын иргэдийг оршин сууж буй орон байрны төрлөөс хамааран гэрт амьдардаг малчид, хот, суурин газрын орон сууц болон гэр хороололд амьдарч буй иргэд гэж 3 төрөлд хувааж байна.

Хүснэгт 24. Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь

	Явц		Зорилт	
	2000*	2006*	2010	2015
Улсын дундаж	22.7	21.4	21.2	30.0

Мэдээллийн эх үүсвэр: * УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

Тооллогын дүнгээр 2010 онд Монгол улсад нийт 553.8 мянган хүн буюу нийт хүн амын 21.2 хувь нь инженерийн шугам сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдарч байна. Энэ нь Монгол улсын нийт хүн амын дөнгөж тавны нэг нь халаалт, халуун, хүйтэн, бохирын усны шугам сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдарч байгааг харуулж байна.

Хүснэгт 25. Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь, бүс нутаг, аймаг, нийслэл, хот, хөдөөгөөр, 2010 он

	Улсын түвшин	Хот	Хөдөө
БҮГД	21.2	30.5	1.4
Баруун бүс	2.4	6.8	0.0
Баян-Өлгий	2.1	5.8	0.0
Говь-Алтай	0.2	0.6	0.0
Завхан	0.1	0.4	0.0
Увс	3.2	8.6	0.0
Ховд	5.3	13.8	0.0
Хангайн бүс	8.4	18.9	0.2
Архангай	2.0	8.0	0.0
Баянхонгор	3.9	9.8	0.0
Булган	2.0	7.3	0.0
Орхон	38.8	39.6	17.1
Өвөрхангай	2.1	5.5	0.0
Хөвсгөл	1.3	3.9	0.0
Төвийн бүс	18.2	32.6	4.9
Говьсүмбэр	36.2	32.8	46.0
Дархан-Уул	46.2	50.7	24.1
Дорноговь	19.7	28.3	7.6
Дундговь	5.0	14.2	0.0
Өмнөговь	3.9	12.1	0.2
Сэлэнгэ	13.6	20.9	6.5
Төв	5.9	30.3	1.3
Зүүн бүс	13.1	28.2	0.3
Дорнод	20.7	36.9	0.1
Сүхбаатар	5.7	16.4	0.8
Хэнтий	10.8	23.4	0.0
Улаанбаатар	35.0	35.0	-

Инженерийн шугам сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь хотод нийт хүн амын 30.5 хувь, хөдөөд нийт хүн амын 1.4 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангасан орон сууцанд амьдарч байна.

Энэ үзүүлэлт Орхон (38.8), Дархан-Уул (46.2), Говьсүмбэр (36.2), Дорнод (20.7) зэрэг аймгуудад нийт хүн амынх нь 20-оос дээш хувьтай байгаа юм.

Монгол Улсын нийт өрх 2010 онд 713.8 мянга болж, түүний 302.2 мянга буюу 42.3 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна. Улаанбаатар хотын хүн ам 2000 онд 760.1 мянга байсан бол 2010 онд 1240.0 мянгад хүрч тус улсын нийт хүн амын 45.0 хувь нь нийслэл хотод амьдарч байна.

Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа нийт хүн амын 400.5 мянга нь буюу 72.3 хувь нь Улаанбаатар хотод ногдож, нийслэлийн нийт хүн амын 35.0 хувь нь инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байна.

Хүснэгт 26. Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн ам, сууцны төрлөөр, бүс нутаг, аймаг, нийслэлээр, 2010 он

	Орон сууцны байшин	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Оюутан, сурагчдын нийтийн байр	Ажиллагчдын нийтийн байр
Улсын дундаж	95.2	2.1	0.8	0.4	1.5
Баруун бүс	87.2	8.0	2.8	0.4	1.6
Баян-Өлгий	74.4	21.6	4.0	0.0	0.0
Говь-Алтай	48.7	19.8	21.6	8.1	1.8
Завхан	81.1	13.5	5.4	0.0	0.0
Увс	92.5	4.8	1.4	0.3	1.0
Ховд	91.2	3.4	2.4	0.4	2.6
Хангайн бүс	93.9	3.1	0.6	0.5	1.9
Архангай	91.2	6.0	1.2	0.6	1.0
Баянхонгор	91.0	6.1	1.5	0.6	0.8
Булган	92.4	1.4	3.5	0.2	2.5
Орхон	95.2	2.5	0.3	0.4	1.6
Өвөрхангай	85.4	5.2	1.8	4.1	3.5
Хөвсгөл	83.2	6.1	1.5	0.1	9.1
Төвийн бүс	92.3	3.5	1.9	0.2	2.1
Говьсүмбэр	95.3	2.0	2.0	0.1	0.6
Дархан-Уул	96.0	1.7	0.6	0.1	1.6
Дорноговь	89.3	3.1	2.6	0.6	4.4
Дундговь	80.9	8.0	10.3	0.8	0.0
Өмнөговь	83.1	9.4	4.3	0.4	2.8
Сэлэнгэ	90.7	5.2	3.3	0.2	0.6
Төв	78.6	11.9	3.2	0.2	6.1
Зүүн бүс	90.9	1.5	3.1	0.3	4.2
Дорнод	87.7	1.4	4.5	0.2	6.2
Сүхбаатар	92.3	4.1	1.2	0.1	2.3
Хэнтий	96.9	0.7	1.1	0.4	0.9
Улаанбаатар	96.3	1.7	0.4	0.5	1.1

Монгол Улсын нийт өрхийн 45.2 хувь нь гэрт, 53.6 хувь нь байшинд, 1.1 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байна. Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амыг сууцны төрлөөр нь авч үзвэл 95.2 хувь нь орон сууцны байшинд, 2.1 хувь нь бие даасан тохилог сууцанд, 0.8 хувь нь сууцны тусдаа байшинд, 0.4 хувь нь оюутан, сурагчдын нийтийн байранд, 1.5 хувь нь ажиллагчдын нийтийн байранд амьдарч байна.

Хүн амын нилээд хувь нь хот, суурин газар амьдарч байгаа хэдий ч орон сууцны нөхцөл байдал ялгаатай, ихэнх нь инженерийн болон нийгмийн дэд бүтэц, хангамж, түүний найдвартай үйлчилгээгээр хангагдаж чадахгүй байна. Монгол улсын Засгийн газраас хүн амыг орон сууцжуулах бодлогын хүрээнд “40000 айлын орон сууц”, “100000 айлын орон сууц” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа хэдий ч хот, суурин газар дахь хүн амын шилжилт хөдөлгөөн ихээхэн нэмэгдэж байгаа тул хот суурин газарт амьдарч буй оршин суугчдыг орон сууцаар хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн гэр хорооллын оршин суугчдын амьдрах орчин, сууцны нөхцөлийг сайжруулах бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай. Эрүүл ахуйн шаардлага хангахуйц нөхцөлд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь Хүн ам орон сууцны тооллогын мэдээллээр гарч буй учраас тооллого хоорондын онуудаар хэрэгжилтийг хэмжих, дүгнэх боломжгүйг энд тэмдэглэж байна.



Хрмррд твр зрхэм. Тлрд хрмррн эрдэнэ



ЗОРИЛГО НАЙМ. ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

ЗОРИЛТ 21: МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, "МЭДЭЭЛЭЛЖСЭН НИЙГЭМ БАЙГУУЛАХ"

ҮЗҮҮЛЭЛТ:

8.13 Интернет байнгын хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд)

8.14 Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд)

8.13 ИНТЕРНЕТ БАЙНГЫН ХЭРЭГЛЭГЧДИЙН ТОО (1000 ХҮН ТУТАМД)

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ТООЦОХ АРГА ЗҮЙ

Интернет байнгын хэрэглэгчдийн тоо нь 1000 хүн тутамд ногдох интернет байнгын хэрэглэгч нарын тоог илэрхийлнэ. Интернет нь дэлхий дахины мэдээллийн нэгдсэн сүлжээ бөгөөд сүлжээний төгсгөлийн төхөөрөмж нь компьютер байна. Dial-up болон түрээсийн шугам, өргөн зурвасын хэрэглэгчдийг нийтэд нь интернетийн байнгын хэрэглэгч гэнэ. Dial-up нь телефон шугам ба модемоор дамжин интернетэд холбогдох боломж юм.

Хөгжлийн процесст оролцож байгаа хүмүүсийн харилцаа холбоог шаардлагатай дэд бүтэцгүйгээр төсөөлөхийн аргагүй. Энэ үзүүлэлтээр мэдээлэл, харилцаа холбооны технологийн хүртээмж, хүн амд мэдээлэл, мэдлэгийг олгох боломжоор хэр хангагдаж байгааг хянана.

1000 хүн тутамд ногдох интернет байнгын хэрэглэгчдийн тоог интернет хэрэглэгчдийн тооны нийлбэрийг хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж 1000-аар үржүүлэн промилиэр илэрхийлнэ.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Сүүлийн жилүүдэд мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарт хурдацтайгаар өөрчлөлт, дэвшилт гарч байна. Нийгэм, эдийн засгийн бүхий л салбар мэдээллийн технологийн хөгжлийн үр шимийг хүртэж, түүний хэрэгцээ шаардлага байнга өссөөр байна. Монгол улсад 10 гаруйхан жилийн өмнө нэвтэрч эхэлсэн үүрэн холбоо, интернет нь өнөөдөр хүмүүсийн өдөр тутмын хэрэглээ болж, хэрэглэгчдийн тоо нь улам бүр нэмэгдсээр байна.

Манай улс 2004 оныг хүртэл интернетийн нэг гарцтай, 78 Мб/с багтаамжтай байсан бол 2010 оны байдлаар 6 гарцтай болж 11.2 Гб/с буюу 14 дахин нэмэгдсэн өндөр хурдаар дэлхийн мэдээллийн сүлжээнд холбогдож байна. Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын мэдээллээр 2010 оны байдлаар интернетийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо 77 болжээ.

Интернет байнгын хэрэглэгчдийн тоог анх удаа Хүн ам, орон сууцны тооллогоор гэртээ болон бусад газар интернетийг байнга хэрэглэдэг 6 болон түүнээс дээш насны хүний тоогоор гаргасан бөгөөд интернетийг зөвхөн шаардлагатай үедээ хэрэглэдэг хэрэглэгчийн тоог энд оруулаагүй болно.

Өмнөх онуудын мэдээлэл нь Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын мэдээлэлд үндэслэн гарч байсан бөгөөд интернетийн байнгын хэрэглэгчийн тоог гаргахдаа сар бүр тодорхой хэмжээний төлбөр төлж интернетийг тогтмол хэрэглэдэг хэрэглэгчийн тоогоор авч байв. Энд хэрэглэгч нь интернетийн үйлчилгээ үзүүлэгч оператортай гэрээ хийж, төлбөр төлдөг өрх болон байгууллагын тоог хамарч байсан бөгөөд тухайн өрх болон байгууллагад хэдэн хүн хэрэглэгч байгааг бүрэн тодорхойлж байгаагүй болно.

Хүснэгт 27. Интернет байнгын хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд)

	Явц		Зорилт	
	2000*	2005*	2010	2015
Улсын дундаж	2.2	8.6	141.2	30.0

Мэдээллийн эх үүсвэр: * МШХХТГ

Монгол улс 1000 хүн тутамд ногдох интернетийн байнгын хэрэглэгчийн тоог 2015 он гэхэд 30 хүнд хүргэх зорилт тавьсан. Гэтэл 2010 оны тооллогын мэдээллээр энэ үзүүлэлт 141.2 хүнд хүрч, 2015 оны зорилтоос даруй 4.7 дахин өндөр байгаа нь манай улс энэ зорилтоо бүрэн хангасныг илтгэж байна.


Хүснэгт 28. Интернет байнгын хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд), бүс нутаг, аймаг, нийслэл, хүйсээр, 2010 он

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Улсын дундаж	141.2	132.3	150.0
Баруун бүс	31.6	29.5	33.8
Баян-Өлгий	27.0	27.8	26.3
Говь-Алтай	30.4	27.3	33.4
Завхан	34.1	30.3	38.0
Увс	30.3	28.2	32.4
Ховд	36.9	33.7	40.1
Хангайн бүс	49.1	44.1	54.0
Архангай	22.4	18.5	26.2
Баянхонгор	31.9	26.9	36.9
Булган	33.3	28.7	38.2
Орхон	148.5	142.2	154.6
Өвөрхангай	30.8	25.7	35.9
Хөвсгөл	27.6	24.2	31.1
Төвийн бүс	76.8	70.9	83.2
Говьсүмбэр	91.7	83.2	100.6
Дархан-Уул	141.2	134.0	148.2
Дорноговь	82.0	73.3	90.9
Дундговь	43.2	36.0	50.6
Өмнөговь	78.7	80.3	76.7
Сэлэнгэ	55.4	49.8	61.2
Төв	40.0	34.7	45.8
Зүүн бүс	46.5	41.1	52.0
Дорнод	61.4	52.0	71.0
Сүхбаатар	34.6	31.7	37.6
Хэнтий	40.0	37.2	42.9
Улаанбаатар	255.5	245.8	264.6

Интернет байнгын хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд)-гоор Архангай аймаг 22.4 хүнтэйгээр хамгийн бага хэрэглэгчтэй бол Улаанбаатар хот 255.5 хэрэглэгчтэйгээр хамгийн их хэрэглэгчтэй байна.

1000 хүн тутамд ногдох интернет байнгын хэрэглэгчийн тоог хүйсээр авч үзэхэд 1000 эрэгтэйд ногдох интернет хэрэглэгчдийн тоо 132.3, 1000 эмэгтэйд ногдох интернет хэрэглэгчдийн тоо 150.0-д хүрчээ. Аль ч бүсийн түвшинд 1000 хүн тутамд ногдох интернет байнгын хэрэглэгчийн тоогоор эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү байна.

Зураг 8. Интернет байнгын хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд), бүс нутаг, хот, хөдөө, хувиар, 2010 он



Тооллогын дүнгээр 1000 хүн тутамд ногдох интернетийн байнгын хэрэглэгчийн тоо улсын түвшинд Улаанбаатар (255.5), Дархан-Уул (141.2), Орхон (148.5) аймгаас бусад аймгуудад 100 хүнд хүрэхгүй буюу 27.0-91.7 хүн байна.

Хүснэгт 29. Интернет байнгын хэрэглэгчдийн тоо, мян.хүн, бүс нутаг, хот, хөдөө, хүйсээр, 2010 он

Бүс	Улсын түвшин			Хот			Хөдөө		
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Улсын дундаж	373.8	173.8	200.0	362.7	168.1	194.6	11.1	5.7	5.4
Баруун бүс	11.2	5.2	5.9	9.9	4.6	5.3	1.3	0.6	0.7
Хангайн бүс	25.3	11.3	13.9	22.9	10.3	12.6	2.4	1.0	1.4
Төвийн бүс	33.9	16.1	17.7	27.5	12.6	14.9	6.4	3.5	2.9
Зүүн бүс	8.6	3.9	4.7	7.5	3.3	4.2	1.1	0.5	0.6
Улаанбаатар	295.0	137.2	157.7	295.0	137.2	157.7	-	-	-

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр интернет байнгын хэрэглэгчийн тоо 373.8 мянгад хүрч, үүний 78.9 хувь буюу 295.0 мянган хэрэглэгч нь Улаанбаатар хотод амьдарч байна. Интернет байнгын хэрэглэгчийн тоо хот, хөдөөд ихээхэн ялгавартай байгаа бөгөөд хотод 96.9 хувь буюу 362.7 мянган хүн, хөдөөд 3.1 хувь буюу 11.1 мянган хүн ногдож байна.

8.14 ҮҮРЭН ТЕЛЕФОН ХЭРЭГЛЭГЧДИЙН ТОО (1000 ХҮН ТУТАМД)

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, ТООЦОХ АРГА ЗҮЙ

Үүрэн технологид суурилсан, нийтийн телефон сүлжээнд холбогдсон авсаархан зөөврийн телефон /гар утас/ хэрэглэгчийг үүрэн телефоны хэрэглэгч гэнэ.

Харилцаа холбооны дэвшлийг хот, хөдөөгийн хүн ам хүртэж, ашигласнаар бараа, бүтээгдэхүүний зах зээлийн үнийг мэдэрч, худалдан авах бараа бүтээгдэхүүнээ зах зээлийн өрсөлдөөнт үнээр худалдах боломжтой төдийгүй мөн е-сургалтад хамрагдах, интернетээс ном, хэвлэлээ шууд унших зэргээр боловсролын түвшинг хөгжүүлэх арга хэрэгсэл болж байна.

Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд)-г үүрэн телефоны урьдчилсан болон дараа төлбөрт хэрэглэгчдийн тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, промилиэр илэрхийлнэ.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Үүрэн телефон Монгол улсад нэвтэрсэн цагаас хойш хэрэглэгчдийн тоо жил бүр өсөн нэмэгдсээр өнөөгийн байдлаар бүх аймгийн сумдад үүрэн телефоны үйлчилгээ нэвтэрч, нийт хүн амын 65 хувь нь үүрэн телефон хэрэглэж байна. Үүрэн телефоны хэрэглэгчдийн тоо 2010 оны тооллогоор 1.7 саяд хүрчээ.

Үүрэн телефоны хэрэглэгчдийн тоог анх удаа Хүн ам, орон сууцны тооллогоор гаргаж байгаа бөгөөд тэдгээрийн талаарх өмнөх онуудын мэдээлэл нь Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын мэдээлэлд үндэслэн гарч байв. Нэг хэрэглэгч нэгээс дээш операторын үүрэн телефоныг ашиглах боломжтой тул дээрх газрын мэдээллээр хэрэглэгчийн тоо давхардсан тоогоор гарч байсныг тэмдэглэж байна.

Харин Хүн ам, орон сууцны тооллогын мэдээллээр хэрэглэгч хэдэн ч операторын үүрэн телефоныг ашиглаж байгаагаас үл хамааран тухайн хэрэглэгч нь үүрэн телефоны нэг хэрэглэгч гэж тоологдсон байгаа тул хэрэглэгчийн тоонд давхардал гараагүй юм.

Хүснэгт 30. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (6, түүнээс дээш насны хүн ам), бүс нутаг, аймаг, нийслэл, хүйсээр, 2010 он

	2010	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1 714 645	826 860	887 785
Баруун бүс	161 523	83 185	78 338
Баян-Өлгий	27 113	14 704	12 409
Говь-Алтай	29 219	14 741	14 478
Завхан	33 524	16 991	16 533
Увс	33 968	17 802	16 166
Ховд	37 699	18 947	18 752
Хангайн бүс	279 699	136 048	143 651
Архангай	38 757	18 735	20 022
Баянхонгор	39 811	19 374	20 437
Булган	29 006	14 482	14 524
Орхон	63 544	30 257	33 287
Өвөрхангай	53 011	25 897	27 114
Хөвсгөл	55 570	27 303	28 267
Төвийн бүс	288 100	144 069	144 031
Говьсүмбэр	8 568	4 276	4 292
Дархан-Уул	65 581	31 083	34 498
Дорноговь	37 319	17 945	19 374
Дундговь	22 459	10 779	11 680
Өмнөговь	42 256	24 533	17 723
Сэлэнгэ	61 553	30 215	31 338
Төв	50 364	25 238	25 126
Зүүн бүс	100 489	49 003	51 486
Дорнод	40 334	19 351	20 983
Сүхбаатар	23 751	12 025	11 726
Хэнтий	36 404	17 627	18 777
Улаанбаатар	884 834	414 555	470 279

Тооллогоор 1.7 сая хүн үүрэн телефон хэрэглэж байгаагийн 0.8 сая нь эрэгтэйчүүд, 0.9 сая нь эмэгтэйчүүд байна. Үүрэн телефон хэрэглэгчийн тоогоороо Зүүн бүс хамгийн бага 100.5 мянган хэрэглэгчтэй байгаа бол Улаанбаатар хот хамгийн их 884.8 мянган хэрэглэгчтэй байна.

Хүснэгт 31. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (1000 хүн тутамд)

	Явц		Зорилт	
	2000*	2005*	2010	2015
Улсын дундаж	31.2	224.0	647.6	350.0

Мэдээллийн эх үүсвэр: * МШХХТГ

